

ГАРЧИГ	
НЭГ. СУМЫН ТАНИЛЦУУЛГА, ХӨГЖЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО	4
1.1 Танилцуулга	5
1.2 Бүс нутгийн хөгжлийн чиг хандлага, бодлого	5
ХОЁР. ГАЗРЫН НӨӨЦ, АШИГЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ	9
2.1 Бэлчээрийн газрын экологийн чадавхийн үнэлгээ	9
2.1.1 Бэлчээрийн газрын экологийн чадавхийн үнэлгээ	14
2.2 Бэлчээрийн газрын эдийн засгийн үнэлгээ тооцох арга зүй	16
2.2.1 Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээ, бэлчээрийн багтаамжийг тооцох	16
2.2.2 Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох (Хонин сүрэг)	17
2.2.3 Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох (Ямаан сүрэг)	19
ГУРАВ. СУМЫН ГАЗРЫН ТОХИРОМЖТОЙ БОЛОН ХЭРЭГЦЭЭТ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	24
3.1 Сумын газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ	24
3.1.1 Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ	24
3.1.2 Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ	26
3.1.3 Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ	40
3.1.4 Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээ	43
3.1.5 Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ	45
3.1.6 Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ	49
3.1.7 Хөв цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээ	51
3.1.8 Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ	53
СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	55
4.1 Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө	55
4.2 Хамгаалалтын бүсийн төлөвлөгөө	57
4.2.1 Усны хамгаалалтын бүс	57
4.2.2 Зам, шугам сүлжээний хамгаалалтын бүс	59
4.2.3 Ойн хамгаалалтын бүс	60
4.3 Хөдөө аж ахуйн газрын төлөвлөгөө	61
4.3.1 Бэлчээрийн газрын төлөвлөгөө	61
4.3.2 Бэлчээр усжуулалтын төлөвлөгөө	65
4.3.3 Бэлчээрийн ашиглалтын хэсгийн төлөвлөгөө	67
4.3.4 Хадлангийн газрын төлөвлөгөө	71
4.4 Хот тосгон бусад суурин газрын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө	73
4.4.1 Аялал жуулчлалын газрын төлөвлөгөө, маршрут	73
4.5 Зам, шугам сүлжээний газрын төлөвлөгөө	75
4.5.1 Шинээр байгуулах хатуу хучилттай болон сайжруулсан авто замын газрын төлөвлөгөө	75
4.5.2 Засах зам гүүр, даваа, бартаатай авто замын газрын төлөвлөгөө	76
4.5.3 Шинээр байгуулах эрчим хүчний шугамын газрын төлөвлөгөө	78
4.6 Зүй ёсны эрхээр ашиглах нутаг дэвсгэрийн төлөвлөгөө	78
ДҮГНЭЛТ	81
АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ	82

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Бэлчээрийн ангилал.....	10
Хүснэгт 2. Бэлчээрийн газрын жилийн нийт ургац	16
Хүснэгт 3. Малын бэлчээрээс өдөрт идэх өвсний хэмжээ, улирал тус бүрээр.....	16
Хүснэгт 4. Хонин сүргийн нядалгааны гарц.....	17
Хүснэгт 5. Монгол хонины махны гарц.....	17
Хүснэгт 6. Хонин сүргийн зохистой харьцаа	17
Хүснэгт 7. Хонины махны ашиг шимийг бий болгох боломжийг тооцсон үр дүн.....	18
Хүснэгт 8. Хонины сүү бий болгох чадавхийг тооцсон дүн	18
Хүснэгт 9. Хонины ноос бий болгох чадавхийг тооцсон дүн.....	19
Хүснэгт 10. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцсон дүн	19
Хүснэгт 11. Нядалгааны гарц.....	20
Хүснэгт 12. Монгол ямааны махны гарц	20
Хүснэгт 13. Ямаан сүргийн зохистой харьцаа.....	20
Хүснэгт 14. Ямааны махны ашиг шимийг бий болгох боломжийг тооцсон дүн	21
Хүснэгт 15. Ямааны сүү бий болгох чадавхийн үзүүлэлт	22
Хүснэгт 16. Ямааны ноолуур бий болгох чадавхийг тооцох үзүүлэлт	22
Хүснэгт 17. Бэлчээрийн газрын газрын бүтээгч чадавхийг тооцсон дүн	23
Хүснэгт 18. Тариаланд тохиромжтой газрын хэмжээ, га	25
Хүснэгт 19. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /Өвөл-хавар/.....	27
Хүснэгт 20. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /Өвөл-хавар/.....	28
Хүснэгт 21. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /Зун-намар/.....	34
Хүснэгт 22. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /Зун-намар/	34
Хүснэгт 23. Шинээр байгуулах хот, суурин газарт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га.....	41
Хүснэгт 24. Аялал жуулчлалын газарт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га.....	44
Хүснэгт 25. Авто замд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га	46
Хүснэгт 26. Шугам сүлжээнд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га.....	48
Хүснэгт 27. Ойн санд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га.....	49
Хүснэгт 28. Хадгалан хамгаалахад тохиромжтой газрын талбайн хэмжээ	53
Хүснэгт 29.Хамгаалалтын бүсүүдийн норм, норматив	57
Хүснэгт 30. Усны хамгаалалтын бүсүүдийн талбай	58
Хүснэгт 31. Зам, шугам сүлжээний газрын хамгаалалтын бүсийн талбай	60
Хүснэгт 32. Сумын улирлын бэлчээрийн талбай, багаар	63
Хүснэгт 33. Бэлчээр усжуулалтын судалгаа.....	65
Хүснэгт 34. Бэлчээр ашиглалтын хэсгийн малчдын улирлын байршил.....	67
Хүснэгт 35. Бэлчээр ашиглалтын хэсгийн даац	69
Хүснэгт 36. Бэлчээр ашиглалтын хэсгийн багтаамж.....	69
Хүснэгт 37. Хадлангийн газрын төлөвлөгөө	71
Хүснэгт 38. Аялал жуулчлалын маршрут	74
Хүснэгт 39. Шинээр байгуулах замын төлөвлөгөө	76
Хүснэгт 40. Гүүрийн төлөвлөгөө, байршил.....	76
Хүснэгт 41. Шинээр байгуулах эрчим хүчний шугамын төлөвлөгөө	78

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Ургамлын экологийн хэв шинжийн зураг	13
Зураг 2. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг.....	26
Зураг 3. Өвөл-Хаврын улиралд адуунд тохирох бэлчээрийн зураг.....	29
Зураг 4. Өвөл-Хаврын улиралд хонинд тохирох бэлчээрийн зураг	30
Зураг 5. Өвөл-Хаврын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн зураг	31
Зураг 6. Өвөл-Хаврын улиралд үхэрт тохирох бэлчээрийн зураг	32
Зураг 7. Өвөл-Хаврын улиралд ямаанд тохирох бэлчээрийн зураг.....	33
Зураг 8. Зун-намрын улиралд адуунд тохирох бэлчээрийн зураг.....	35
Зураг 9. Зун-намрын улиралд хонинд тохирох бэлчээрийн зураг	36
Зураг 10. Зун-намрын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн зураг	37
Зураг 11. Зун-намрын улиралд үхэрт тохирох бэлчээрийн зураг	38

Зураг 12. Зун-намрын улиралд ямаанд тохирох бэлчээрийн зураг	39
Зураг 13. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	42
Зураг 14. Аялал рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	45
Зураг 15. Авто зам болон төмөр замын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	47
Зураг 16. Цахилгаан дамжуулах агаарын шугамын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	48
Зураг 17. Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	50
Зураг 18. Хөв, цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	52
Зураг 19. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг	54
Зураг 20. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний зураг	56
Зураг 21. Хамгаалалтын бүсийн төлөвлөгөөний зураг	61
Зураг 22. Улирлын бэлчээр ашиглалтын зураг	64
Зураг 23. Усжуулах бэлчээрийн төлөвлөгөөний зураг	66
Зураг 24. Бэлчээр ашиглалтын хэсгийн төлөвлөгөөний зураг	68
Зураг 25. Хадлангийн газрын төлөвлөгөөний зураг	72
Зураг 26. Хот, суурин газрын функциональ бүсийн төлөвлөлтийн зураг	73
Зураг 27. Аялал жуулчлалын газрын төлөвлөгөөний зураг	75
Зураг 28. Авто замын газрын төлөвлөгөөний зураг	77
Зураг 29. Зүй ёсны эрхээр баталгаажуулах төлөвлөгөө	80

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Чулуурхаг хөрстэй уулын энгэр болон цав толгодын орой, хажуугийн ботууль-алаг өвст бэлчээрийн төлөв байдлын загвар	14
График 2. Уулын бэл хөндийн шавранцар хөрстэй жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст бэлчээрийн төлөв байдлын загвар	15
График 3. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд	25
График 4. Тариалангийн газрын тохиромжтой байдлын эзлэх хувь	25
График 5. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний схем	27
График 6. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /Өвөл-хавар/	28
График 7. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /Зун-намар/	34
График 8. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ	40
График 9. Шинээр байгуулах хот, суурин газарт тохиромжтой газрын эзлэх хувь	41
График 10. Ландшафтын үнэлгээний схем	44
График 11. Аялал жуулчлалын газарт тохиромжтой газрын эзлэх хувь	44
График 12. Шугаман байгууламжийн тохиромжтой байдлын үнэлгээ	46
График 13. Авто замд тохиромжтой газрын талбайн эзлэх хувь	46
График 14. Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээ	49
График 15. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний үндсэн чиглэл	55
График 16. Улирлын бэлчээрийн эзлэх хувь	63
График 17. Аялал жуулчлалын маршрут	74

НЭГ. СУМЫН ТАНИЛЦУУЛГА, ХӨГЖЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО

Энэхүү сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын гол зорилго нь Хэнтий аймгийн Батширээт сумын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд газар болон байгалийн нөөц нөхцөлийг зүй зохистой ашиглуулах боломжийг судалсны үндсэн дээр газрын тохиромжтой байдлын үнэлгээнд суурилсан, нутаг дэвсгэрийн цаашдын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад чиглэсэн ажил болно.

Төлөвлөгөөний ажлын зураг төслийг Хэнтий аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, “Вектор мэт” ХХК хамтран Газар зохион байгуулалт, Геодези, Зурагзүйн газрын даргын 2017 оны 11-р сарын 24 өдрийн А/278 тушаалаар батлагдсан сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүйн дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Уг төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, салбарын норм дүрэм, Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021), Аймаг, сум, орон нутгийн байгууллага, мэргэжилтнүүд, орон нутгийн иргэдийн санал, Хэнтий аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тус тус ашиглав.

1.1 Танилцуулга



Ажлын нэр: Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах

Зорилго: Сумын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд газар ашиглалтын хэлбэр бүрээр тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээн дээр суурилж сумын газар ашиглалтын байдлыг тогтоож хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад оршино.

Байршил: Хэнтий аймаг, Батширээт сум

Хамрагдах газрын хэмжээ: Сумын хот тосгон бусад суурины газраас бусад нийт газрыг хамарна.

Хамрагдах олон нийт: Сумын 871 өрх, 2312 хүн амтай.

Ажлын үр дүн: Сумын нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарсан газар зохион байгуулалтын цогц төлөвлөгөөний бичиг баримт болох нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй болохоос гадна газар, түүний байгалийн нөөц, ашиглалтын цогц шинэчлэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, газар нутаг, түүний нөөц, баялгийг зүй ёсны зориулалтаар нь ашиглах суурь судалгаа, нөхцөл бүрдэж байна.

1.2 Бүс нутгийн хөгжлийн чиг хандлага, бодлого

Хэнтий аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2010 оны 5-р сарын 22-ний өдрийн 4-р хуралдааны 04 дугаар тогтоолоор батлагдсан “Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)” -д нийцүүлэв.

Хэнтий аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2021 он)

Хэнтий аймгийн хөгжлийн алсын хараа: Хэнтий аймгийн хөгжлийн 2021 он хүртэлх алсын хараа нь хүний хөгжилд тулгуурлан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж хүн амын амьдралын түвшинг тууштай дээшлүүлэн, мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, Монгол улсын өөрөө өөрийгөө тэтгэдэг, оновчтой бүтэцтэй, мэдлэгт суурилсан эдийн засагтай, зүүн бүсийн цэцэглэн хөгжиж буй аймаг болоход оршино.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он)-ны эцэст эдийн засгийн бүтэц ихээхэн сайжирч, дэвшилтэт техник технологи, менежмент бүхий үйлдвэрлэл үйлчилгээ өсөн, мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурь тавигдах ба өмнөх шатанд байгуулагдсан уул уурхайн болон боловсруулах салбарын үйлдвэрүүдийн үйл ажиллагаа жигдэрнэ. Эдийн засаг нь энэ үе шатанд жилд дунджаар 9.4 хувиар өснө. Аймгийн ДНБ-ий 4.7 хувийг аж үйлдвэр, барилгын салбарт, 47.3 хувийг орчин үеийн үйлчилгээний салбар үйлдвэрлэнэ.

Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого:

Хоёрдугаар үе шат (2016-2021 он)

- ✚ Стратегийн зорилт 1. Ядуурлыг бууруулахад бүхий л хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тэгш оролцоог ханган ядуурлыг эрс бууруулна.
- ✚ Стратегийн зорилт 2. Нэн ядуу иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг боловсронгуй болгоно.

Хүн ам зүйн бодлого:

Хоёрдугаар үе шат (2016-2021 он)

- ✚ Стратегийн зорилт 1. Хүн амын жилийн дундаж өсөлтийг 2.0 хувьд хүргэнэ.
- ✚ Стратегийн зорилт 2. Хүнийг хөгжүүлэх боломжийг бүрэн дүүрэн ашиглах замаар аймгийн хэмжээнд хүний хөгжлийн индексийн дундаж үзүүлэлтийг 0.72-аас бууруулахгүй байна.

Боловсрол, соёлын хөгжлийн бодлого:

Хоёрдугаар үе шат (2016-2021 он)

- ✚ Стратегийн зорилт 1. Аймгийн боловсролын тогтолцоо, сургалтын хэв шинжийг олон улсын нийтлэг жишигт хүргэнэ.
- ✚ Стратегийн зорилт 2. Соёл урлагийн байгууллагуудын ажиллах оновчтой тогтолцоо бүрдүүлэн, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.

Эрүүл мэндийн хөгжлийн бодлого:

Хоёрдугаар үе шат (2016-2021 он)

- ✚ Стратегийн зорилт 1. Эрүүл мэндийн салбарын материаллаг баазыг бэхжүүлж, удирдлага, санхүүжилтийн нэгдмэл тогтолцоог хөгжүүлнэ.

Макро эдийн засгийн бодлого:

Хоёрдугаар үе шат (2016-2021 он)

- ✚ Стратегийн зорилт 1. Энэ үе шатанд тус аймаг жилд 341844.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэж, нэг хүнд ногдох үйлдвэрлэлийн хэмжээ 2021 онд 3829.1 мянган төгрөгт хүрч 2009 онтой харьцуулбал 2.3 дахин нэмэгдэнэ. Аймгийн салбарын бүтцэд томоохон өөрчлөлт гарч, ДНБ-ий 25.9 хувийг уул уурхай, боловсруулах үйлдвэр, эрчим хүч, барилгын салбарт, 35.0 хувийг ХАА-н салбарт, 39.18 хувийг үйлчилгээний салбарт үйлдвэрлэнэ.

Боловсруулах аж үйлдвэрийн хөгжлийн бодлого:

Хоёрдугаар үе шат (2016-2021 он)

- ✚ Стратегийн зорилт 1. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд 2016 онтой харьцуулахад 3.5 хувиар нэмэгдүүлж, аймгийн ДНБ-ий 14.8

хувьд хүргэж экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлнэ.

Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого:

Хоёрдугаар үе шат (2016-2021 он)

- ✚ Стратегийн зорилт 1. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн салбарын ДНБ-ийг жилд дунджаар 2.7 хувиар өсгөнө.

Хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого:

Хоёрдугаар үе шат (2016-2021 он)

- ✚ Стратегийн зорилт 1. Биотехнологийг тууштай нэвтрүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулж, таримлын ургацыг нэмэгдүүлэн ХАА-н салбарын үйлдвэрлэлийг жилд дунджаар 3.8 хувиар өсгөнө.

Аялал жуулчлалын хөгжлийн бодлого:

Хоёрдугаар үе шат (2016-2021 он)

- ✚ Стратегийн зорилт 1. Аялал жуулчлалын салбарын жилийн дундаж өсөлтийг 35.4 хувьд хүргэж, үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэнэ.

Зам, тээврийн хөгжлийн бодлого:

Хоёрдугаар үе шат (2016-2021 он)

- ✚ Стратегийн зорилт 1. Автозамын сүлжээг өргөтгөн, агаарын тээврийг эрчимтэй хөгжүүлнэ.

Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого:

Хоёрдугаар үе шат (2016-2021 он)

- ✚ Стратегийн зорилт 1. Эрчим хүчний менежментийг боловсронгуй болгож, байгаль орчинд халгүй тэргүүний техник технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээний үр ашгийг дээшлүүлнэ.

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн бодлого:

Нэгдүгээр үе шат (2010-2021 он)

- ✚ Стратегийн зорилт 1. Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц, сүлжээг шинэчлэх замаар “Мэдээлжсэн нийгэм”-ийг байгуулах суурь үндсийг бүрдүүлнэ.
- ✚ Стратегийн зорилт 2. Аймаг сумдын мэдээлэл, харилцаа холбооны дамжуулах сүлжээг шилэн кабель, сансрын холбоо, радио холбоогоор шинэчлэнэ.
- ✚ Стратегийн зорилт 3. Мэдээлэл, харилцаа холбооны шинэ үйлчилгээ хэрэглээг төр, аж ахуйн болон үйлчилгээний бүхий л байгууллагуудад өргөн нэвтрүүлнэ.
- ✚ Стратегийн зорилт 4. Аймгийн хэмжээнд мэдээлэл, харилцаа холбооны мэргэжилтэн бэлтгэх чадавхийг бүрдүүлэн, хүний нөөцийг хөгжүүлнэ.

Хот байгуулалт, барилгын салбарыг хөгжүүлэх бодлого:

Хоёрдугаар үе шат (2016-2021 он)

- ✚ Стратегийн зорилт 1. Хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан иргэдийн орон сууцны хангамжийн түвшинг дээшлүүлнэ.

Ойн нөөц ашиглалт, хамгааллын талаар:

- ✚ Ойг нөхөн сэргээх, төв суурин газрыг цэцэрлэгжүүлэхэд шаардлагатай тарьц, суулгац бэлтгэх, мод үржүүлгийн газруудыг сумдад байгуулж байнгын ажиллагаатай болгох;
- ✚ Хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, ойн түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх хохирлыг арилгах арга хэмжээг шинэ шатанд гаргаж, орон нутгийн иргэдийн оролцоог эрс нэмэгдүүлж, тэдэнд гэрээгээр хариуцуулан хамгаалуулах ойн сангийн хэмжээг нийт ойн сангийн 50 хувьд хүргэх.

Биологийн төрөл зүйлийн хамгааллын талаар:

- ✚ Сум бүрийн газар ашиглалтын төлөвлөлтөд биологийн төрөл зүйлийн амьдрах орчныг хамгаалах асуудлыг тусгаж хэвшүүлэх;
- ✚ Ховор ан амьтан үржиж төллөдөг, нүүдлийн болон суурин амьдардаг шувууд өндөглөдөг болон ховор ургамал бүхий газар нутгийг нөөцлөн үлдээх арга хэмжээ авах;
- ✚ Байгаль орчны доройтол, биологийн төрөл зүйлийн хомсдлыг хязгаарлан зогсоох, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх ач холбогдол бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах;

ХОЁР. ГАЗРЫН НӨӨЦ, АШИГЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ

2.1 Бэлчээрийн газрын экологийн чадавхийн үнэлгээ

Хэнтий аймгийн Батширээт сумын бэлчээрийн чадавхийн байдлаар ангилахдаа ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/104 тушаалын хавсралтаар батлагдсан “Бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загварыг ашиглах зөвлөмж”-ийн дагуу Монгол орны байгалийн бүс, бүслүүр бүрээр ангилсан 25 төрлийн бэлчээрийн ангиллыг ашигласан. Мөн тус сумын бэлчээрийн газрын төлөв байдлыг ангилахдаа 2009 оны ГХБГЗЗГ-ын даргын тушаалаар батлагдсан “Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг гүйцэтгэх, үр дүнг хүлээн авах журам”-ын дагуу хийж гүйцэтгэсэн.

Хэнтий аймгийн Батширээт сум нь Монгол орны байгалийн бүс, бүслүүрийн уулын тайгын бүслүүр, ойт хээрийн бүс болон хээрийн бүс гэсэн бүсүүдэд оршиж байгаа бөгөөд уулын тайгын бүслүүр нь баруун, баруун хойд хэсэгт 312744.06 га, ойт хээрийн бүс тус сумын зүүн, төвийн хэсгээр 375123.0 га, хээрийн бүс урд хэсгээр 14186.46 га талбайг хамарч байна.

Уулын тайгын бүслүүрт өндөр уулын бэлчээр, нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндий гэсэн ангилалтай байх бөгөөд нийт 24283.5 га талбай байна. Уулын тайгын бүслүүрийн өндөр уулын бэлчээрийн уулын царамын хүлрэнцэр ялзмагт, өндөр уулын нугын хар шороорхуу хөрстэй, өндөр уулын нугын бушилж- улалжит, улалж-бушилзат бэлчээр нь 24031.15 га, нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндийн улаан толгой- улалж-алаг өвст, улалж- улаан толгойт зонхилсон бэлчээр 252.36 га талбай хамарч байна.

Ойт хээрт өндөр уулын бэлчээр, бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр, дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр, нам бэсрэг уулын хоорондох нуга хөндий, тал хээрийн бэлчээр гэсэн ангилалтай байх бөгөөд нийт 103306.69 га талбай байна. Уулын царамын хүлрэнцэр ялзмагт, өндөр уулын нугын хар шороорхуу хөрстэй өндөр уулын нугын бушилж-улалж, улалж-бушилзат 13830.33 га, бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр 19589.61 га, голын хөндий нуурын захын аллювийн нугат намгийн хөрстэй нуга намгийн бэлчээр, улалж-үетэнт, үетэн-улалж-алаг өвст, улалж- улаан толгойт, улалж- алаг өвст, улалж- улаан толгойт, бургас- улиаст, улиас-бургаст, бургас- хар модот бэлчээр нь 16301.25 га, аллювийн нугын болон хээржсэн нугын үелсэн сулавтар хөгжилтэй хөрстэй татамын нуга бэлчээр нь 3288.36 га, үетэн-улалж- алаг өвст бэлчээр нь 1512.05 га, улалж-үетэн- алаг өвст 1776.31 га, дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээрийн уулын хар хүрэн ба нугын улирлын цэвдэгт хар шороон хөрстэй нугархаг хээр, үетэн-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн- алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст (20+28), зүр өвст, зүр өвс- алаг өвст, алаг өвс- үетэн-улалжит бэлчээр нь 14684.67 га, уулын сул хөгжилтэй

хар хүрэн ба хар шороон хөрстэй нугархаг хээрийн сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээр нь жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст (20+28), сөөг бүхий алаг өвс- үетэнт, алаг өвс- үетэн-улалжит, сөөг бүхий алаг өвс- үетэнт, жижиг дэгнүүлт үетэн- алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн- алаг өвст, алаг өвс- үетэн- улалжит, жижиг дэгнүүлт үетэн- алаг өвст (20+28) бэлчээр нь 16431.46 га, уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээрийн бэлчээр жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст бэлчээр нь 1156.22 га, нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндийн уулсын хоорондох хөндийн гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нуга, улаан толгой-улалж- алаг өвст, улаан толгой-улалж- алаг өвст, улалж- улаан толгойт, алаг өвс- улалж- үетэнт, алаг өвс- улалж- үетэнт, сөөгт ширэнгэ, төгөл , улалж- үетэнт, улалж-үетэнт, зүрх өвс- хялганат бэлчээр нь 11710.07 га, тал хээрийн бэлчээрийн тэгшивтэр болон нугачаат хөндийн шавранцар хүрэн хөрстэй хээр ботууль- жижиг дэгнүүлт үетэн- алаг өвст, ботууль- жижиг дэгнүүлт үетэн- алаг өвст, хялганат, хялгана- алаг өвст, хялганат, хялгана алаг өвст, үетэн- улалж- алаг өвст, алаг өвс- үетэнт, алаг өвс- үетэнт, жижиг улалж- үетэнт бэлчээр нь 25904.32 га талбай хамарч байна.

Хээрийн бүсэд бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр, дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр, нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндий, тал хээрийн бэлчээр гэсэн ангилалтай байх бөгөөд нийт 13855.31 га талбай байна. Бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээрийн голын хөндий, нуурын захын аллювийн нугат намгийн хөрстэй нуга намгийн бэлчээрийн улалж- үетэнт, улалж- үетэнт, үетэн- улалж- алаг өвст 6513.19 га, аллювийн нугын болон хээржсэн нугын үелсэн сулавтар хөгжилтэй хөрстэй татамын нуга улалж- үетэн- алаг өвст 2491.37 га, нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндийн уулсын хоорондох хөндийн гүндээ цэвдэгтэй, хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нуга алаг өвс- улалж- үетэнт, алаг өвс- улалж- үетэнт, сөөгт ширэнгэ, төгөл 224.02 га, тал хээрийн бэлчээрийн тэгшивтэр болон нугачаат хөндийн шавранцар хүрэн хөрстэй хээр жижиг улалж- үетэнт 4614.21 га талбай хамарч байна.

Хүснэгт 1. Бэлчээрийн ангилал


Уулын тайгын бүслүүр	24283.5
<i>Өндөр уулын бэлчээр-Ө</i>	24031.15
Уулын царамын хүлрэнцэр ялзмагт, өндөр уулын нугын хар шороорхуу хөрстэй өндөр уулын нуга (Ө-II)	24031.15
Бушилж - улалжит, Улалж – бушилзат	24031.15
<i>Нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндий-УХ</i>	252.36
Уулсын хоорондох хөндийн гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нуга (УХ-II)	252.36
Улаан толгой - улалж - алаг өвст	36.58

Улаан толгой - улалж - алаг өвст, Улалж-улаан толгойт, Элс	215.78
<i>Ойт хээр бүс</i>	103306.69
<i>Өндөр уулын бэлчээр-Ө</i>	13830.33
Уулын царамын хүлрэнцэр ялзмагт, өндөр уулын нугын хар шороорхуу хөрстэй өндөр уулын нуга (Ө-II)	13830.33
Бушилж - улалжит, Улалж – бушилзат	13830.33
<i>Бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр-Н</i>	19589.61
Голын хөндий нуурын захын аллювийн нугат намгийн хөрстэй нуга намгийн бэлчээр (Н-I)	16301.25
Улалж-үетэнт, Үетэн-улалж-алаг өвст	10861.78
Улалж-улаан толгойт, Улалж-алаг өвст	2493.22
Улалж-улаан толгойт, Бургас-улиаст, Улиас-бургаст, Бургас-хар модот	2946.26
Аллювийн нугын болон хээржсэн нугын үелсэн сулавтар хөгжилтэй хөрстэй татамын нуга (Н-II)	3288.36
Үетэн-улалж-алаг өвст	1512.05
Улалж-үетэн-алаг өвст	1776.31
<i>Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр-У</i>	32272.36
Уулын хар хүрэн ба нугын улирлын цэвдэгт хар шороон хөрстэй нугархаг хээр (У-II)	14684.67
Үетэн-алаг өвст	910.39
Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст	5024.56
Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст (20+28)	1600.09
Зүр өвст, Зүр өвс - алаг өвст	259.08
Алаг өвс - үетэн – улалжит	6890.55
Уулын сул хөгжилтэй хар хүрэн ба хар шороон хөрстэй нугархаг хээрийн сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээр (У-III)	16431.46
Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст (20+28)	1600.09
Сөөг бүхий алаг өвс - үетэнт, Алаг өвс - үетэн - улалжит	1832.41
Сөөг бүхий алаг өвс - үетэнт, Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст	4520.44
Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст, Алаг өвс - үетэн - улалжит	3261.31
Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст (28+20)	6817.30
<i>Уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээрийн бэлчээр (У-IV)</i>	1156.22
Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст	1156.22
<i>Нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндий-УХ</i>	11710.07
Уулсын хоорондох хөндийн гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нуга (УХ-II)	11710.07
Улаан толгой - улалж - алаг өвст	392.45
Улаан толгой - улалж - алаг өвст, Улалж-улаан толгойт	1633.96

Алаг өвс-улалж – үетэнт	2575.33
Алаг өвс-улалж - үетэнт, Сөөгт ширэнгэ, төгөл	3668.74
Улалж – үетэнт	1878.42
Улалж - үетэнт, Зүр өвс-хялганат	
<i>Тал хээрийн бэлчээр-Х</i>	25904.32
Тэгшивтэр болон нугачаат хөндийн шавранцар хүрэн хөрстэй хээр (Х-I)	25904.32
Ботууль-жигжиг дэгнүүлт үетэн-алаг өвст	7294.21
Ботууль-жигжиг дэгнүүлт үетэн-алаг өвст, Хялганат, хялгана-алаг өвст	2324.07
Хялганат, хялгана-алаг өвст, Үетэн-улалж-алаг өвст	2674.73
Алаг өвс- үетэнт	5190.08
Алаг өвс- үетэнт, Жижиг улалж- үетэнт	7328.7
Жижиг улалж- үетэнт	1092.53
<i>Хээрийн бүс</i>	13855.31
<i>Бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр-Н</i>	9004.56
Голын хөндий нуурын захын аллювийн нугат намгийн хөрстэй нуга намгийн бэлчээр (Н-I)	6513.19
Улалж-үетэнт	76.75
Улалж-үетэнт, Үетэн-улалж-алаг өвст	6436.44
Аллювийн нугын болон хээржсэн нугын үелсэн сулавтар хөгжилтэй хөрстэй татамын нуга (Н-II)	2491.37
Улалж-үетэн-алаг өвст	2491.37
<i>Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр-У</i>	1.145
Уулын хар хүрэн ба нугын улирлын цэвдэгт хар шороон хөрстэй нугархаг хээр (У-II)	1.14
Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст	1.14
Уулын сул хөгжилтэй хар хүрэн ба хар шороон хөрстэй нугархаг хээрийн сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээр (У-III)	0.006
Сөөг бүхий алаг өвс – үетэнт, Жижиг дэгнүүлт үетэн - алаг өвст	0.006
<i>Нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндий-УХ</i>	235.38
Уулсын хоорондох хөндийн гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нуга (УХ-II)	224.02
Алаг өвс-улалж – үетэнт	11.37
Алаг өвс-улалж - үетэнт, Сөөгт ширэнгэ, төгөл	224.02
<i>Тал хээрийн бэлчээр-Х</i>	4614.21
Тэгшивтэр болон нугачаат хөндийн шавранцар хүрэн хөрстэй хээр (Х-I)	4614.21
Жижиг улалж- үетэнт	4614.21
Нийт талбай	141445.5

Бэлчээрийн чадавхийн зургаас харахад Батширээт сумын нутаг дэвсгэрийн хувьд хойд хэсгээр дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр, жижиг дэгнүүлт-алаг өвст

бэлчээр, урд хэсгээр бүс дундын нам, хотосын нугын бэлчээр, гол хөндий, нуурын захын аллювийн нугат намгийн хөрстэй улалж-үетэнт, үетэн-улалж-алаг-өвст бэлчээр зонхилсон.



Зураг 1. Ургамлын экологийн хэв шинжийн зураг

2.1.1 Бэлчээрийн газрын экологийн чадавхийн үнэлгээ

ГХГЗЗГ, УЦУОСМХ, ШХА, Ногоон Алт төслөөс хамтран боловсруулсан “Монгол орны бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загварууд, зөвлөмж”-өөс харахад Батширээт сумын бэлчээрийн газар нь газрын гадаргын тогтоц, хөрс уур амьсгалын нөхцөлөөрөө уулын тайгын бүслүүр, ойт хээр болон хуурай хээрийн бүсэд багтаж байна.

1) Чулуурхаг хөрстэй уулын энгэр болон цав толгодын орой, хажуугийн ботууль-алаг өвст бэлчээр: Тус бэлчээр нь ойт хээрийн бүс багтах бөгөөд энэ нь нутгийн хойд хэсгийг хамрана. Энэ бэлчээр нь харьцангуй сийрэг өвс ургамалжилттай. Уг бэлчээрт том цэцэгт дааган сүүл (*Koeleria macrantha*), саман ерхөг (*Agropyron cristatum*) нар тэргүүн зонхилогчоор оролцдог. Энд үет ургамлаас крыловын хялгана (*Stipa Krylovii*), сунагар биелэг (*Poa attenuata*), шеллийн бутнуур (*Helictotrichon schellianum*) ургах ба үетнүүд нийт бүрхэцийн 45-50 орчим хувийг эзэлдэг. Тухайн бэлчээрийн үндсэн зонхилогч ленийн ботууль (*Festuca lenensis*)-ийн бүрхэц 1-2 хувьтай байгаа нь тухайн зүйлийн үүрэг оролцоо ихээхэн буурсныг харуулж байна. Буурцагтнаас утсан навчит ортууз (*Oxytropis filiformis*), хурц навчинцарт ортууз (*O. oxurphylla*), дайралдмал хунчир (*Astragalus inopinatus*), нарийн хунчир (*A. tenuis*), ижил хунчир (*A. propinquus*) ургах боловч арви төдийлөн их биш байдаг.




График 1. Чулуурхаг хөрстэй уулын энгэр болон цав толгодын орой, хажуугийн ботууль-алаг өвст бэлчээрийн төлөв байдлын загвар

2) Уулын бэл хөндийн шавранцар хөрстэй жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст бэлчээр: Тус бэлчээр нь ойт хээрийн бүс багтах бөгөөд нутгийн баруун хойд болон төв хэсгийн уулархаг хэсгийг хамарна. Ашиглалтын нөлөөгөөр энэ төрлийн бэлчээр багаас дунд зэрэг доройтсон зүйлийн бүрэлдэхүүн өөрчлөлтөнд орж ширэг улалж зонхилсон төлөвт шилждэг. Үүнд ширэг улалж, агь зонхилж үетний хувь буурсан боловч 10-аас дээш хувьтай нэг хувилбар (2.1) ба адамсын шарилж, ишгүй болон имт гичгэнэ түрж ургасан гэсэн (2.2) хоёр янзын хувилбартай байна. Зүүн гурван аймгийн уулын бэл хөндийн шавранцар хөрстэй жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст хамаарах бэлчээрт үет ургамлын хувь өндөр байхад ширэг улалж, адамсын шарилж ихсэх тохиолдол байдгийг чулуурхаг хөрстэй уулын орой болон энгэр хажуугийн крыловын хялгана-үетэн-алаг өвст бэлчээртэй андуурч болохгүй. Чулуурхаг хөрстэй уулын орой болон энгэр хажуугийн крыловын хялгана-үетэн-алаг өвст бэлчээрт ургамлын бүлгэмдэл доройтож зүйлийн баялаг буурахаас гадна халцгай газрын хэмжээ ихсэж, үлийн цагаан оготно олшрох суурь болдог. Уулын бэл хөндийн шавранцар хөрстэй жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст бэлчээрт анхаарах зүйл: Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймагт үетний хувь буураагүй боловч Адамсын шарилж, ширэг улалж их байдаг. Гичгэний оролцоо ихэсдэг. Иймээс үетний хувь болон зургийг харж үнэлэх хэрэгтэй. Чулуурхаг хөрстэй уулын орой болон энгэр хажуугийн крыловын хялгана-үетэн-алаг өвст бэлчээрт анхаарах зүйл: Үлий болон хөрсний доройтлын шинж илэрдэг учир халцгай газар болон хагдны хуримтлалыг харах шаардлагатай (График 2).




График 2. Уулын бэл хөндийн шавранцар хөрстэй жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст бэлчээрийн төлөв байдлын загвар

2.2 Бэлчээрийн газрын эдийн засгийн үнэлгээ тооцох арга зүй

2.2.1 Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээ, бэлчээрийн багтаамжийг тооцох

Бэлчээрийн газрын суурь үнэлгээг тооцохын тулд дараах 3 байдлаар үнэлж тооцлоо.

Үүнд:

1. Хөрсийн чанарын үнэлгээ /Хчү/
2. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээ /БГбчү/
3. МАА үйлдвэрлэлийн бизнес тооцооллын аргаар үнэлсэн үнэлгээ /Окү/

Дээрх 3 үнэлгээгээр бэлчээрийн газрын суурь үнэлгээ /Гсү/ гарах юм.

$$Гсү = Хчү + БГбчү + МААб \quad (1.1)$$

Бэлчээрийн газрын нийт ургац (в)-ыг дараах хүснэгтээр тооцсон болно.

Хүснэгт 2. Бэлчээрийн газрын жилийн нийт ургац

Багийн нэр	Бэлчээрийн талбай /га/	1 га-гийн ургац /цн/	Нийт ургац /цн/
Онон	52381.8	2.91	152221.40
Барх	46153.3	4.20	193843.75
Хурх	38981.3	4.29	167237.61
Норовлин	3929.2	4.13	16215.91
Нийт	141445.5		529518.67

Хүснэгт 3. Малын бэлчээрээс өдөрт идэх өвсний хэмжээ, улирал тус бүрээр

Малын төрөл	Улирал ба өвсний хэмжээ /кг/			
	Зун	Намар	Өвөл	Хавар
Адуу	7.8	8.1	6.5	5.8
Тэмээ	14.1	13	8.4	9.9
Үхэр	8.7	9.7	7.4	7.4
Хонь	1.9	1.6	1.1	1.1
Ямаа	1.3	1.4	1	1

Бэлчээрийн газрын нийт ургацыг мал жилийн 4 улиралд идэх бөгөөд ургац зун ногоон, намар хагдарч эхлэх, өвөл, хавар хагд байдлаар мал идэгддэг билээ. Тиймээс нэг хонин толгойн жилд идэх ургацыг дараах байдлаар тооцно.

$$a1 = \frac{Н*НМз}{100}, \quad a2 = \frac{Н*НМн}{100}, \quad a3 = \frac{Н*НМөх}{100}, \quad (1.2)$$

a1-нэг хонин толгойд идэгдэх ургац /Зун/

a2-нэг хонин толгойд идэгдэх ургац /Намар/

a3-нэг хонин толгойд идэгдэх ургац /Өвөл, хавар/

Н-ногоон масстай байх хоногийн тоо

НМ- нэг өдөр идэх ургац

$$a1 = \frac{90 \cdot 1.9}{100} = 1.71 \text{ тн}, \quad a2 = \frac{45 \cdot 1.6}{100} = 0.504 \text{ тн}, \quad a3 = \frac{230 \cdot 1.1}{100} = 1.265 \text{ тн},$$

$$x1 = \frac{v \cdot a1^2}{a1^2 + a1 \cdot a3 - a1 \cdot a2} = \frac{529518.67 \cdot 2.9241}{2.9241 + 2.16315 + 0.86184} = \frac{1548365.53}{5.94909} = 260269.31$$

Эндээс малд идэгдэх бодит ургац 260269.31 цн байна.

Бэлчээрийн багтаамжийг тооцоходоо малд идэгдэх бодит ургацыг нэг хонин толгойн өдөрт идэх ургацад (1.1) харьцуулж үзэхэд 236608 хонин толгой болж байна.

2.2.2 Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох (Хонин сүрэг)

Хонины махны ашиг шимийг бий болгох боломжийг дараах томъёогоор бодож гаргана.

$$M_T = \frac{\left[\frac{AJ_T}{100} + (AJ_D - AJ_T) \right] НГ_T}{100} \quad (1.3)$$

M_T-Тухайн насны малын махны жилийн өсөлт буюу үйлдвэрлэгдэж буй махны хэмжээ

AJ_D-Дараах насны малын амьдын жин

AJ_T-Тухайн насны малын амьдын жин

НГ-Тооцож буй малын нядалгааны гарц

Хүснэгт 4. Хонин сүргийн нядалгааны гарц

№	Малын төрөл	Нядалгааны гарц хувиар
1	Үхэр	55-65
2	Хонь, ямаа	44-48
3	Адуу	47-54
4	Тэмээ	55-65

Хүснэгт 5. Монгол хонины махны гарц

Насны ялгаа	Амьдын жин /кг/	Гулуузны жин /кг/	Гарц /%/
12 сартай	28.9	10.2	42.5
1.5 настай	43.78	21.1	48.1
2.5 настай	51.0	26.9	52.7
3.5 настай	58.3	32.2	55.3
4.5 настай	60.5	33.5	55.3
5.5 настай	70.9	38.8	54.6

Хүснэгт 6. Хонин сүргийн зохистой харьцаа

№	Нас	Сүрэгт эзлэх хувь	Бүгд
1	1.5	22	5640
2	2.5	14	3589
3	3.5	32	8204
4	Хээлтүүлэгч	1	256
5	Хээлтэгч	31	7948
	Бүгд	100	25637

Статистикийн мэдээллийн сангаас 2016 оны малын тоог ашиглав. Хонины махны ашиг шимийг бий болгох боломжийг тооцож гаргавал дараах байдалтай байна.

Хүснэгт 7. Хонины махны ашиг шимийг бий болгох боломжийг тооцсон үр дүн

Нас, хүйс	Амьдын жин	Зун-намрын улиралд нэмэгдэх (нэг хонин толгойд)				Малын тоо	Бүгд нэмэгдэх
		Өвөл-хавар алдсан жин /кг/	Нас дэвших хүртлэх нэмэгдэх жин /кг/	Бүгд нэмэгдэх	Бүгд нэмэгдэл нядалгааны гарцаар		
1.5	43.8	13.1	7.2	20.3	9.7	5640	54708
2.5	51	15.3	7.3	22.6	10.8	3589	38761
3.5	58.3	17.5	2.2	19.7	9.5	8204	77938
Хээлтүүлэгч	57	17.1	14	31.1	14.9	256	3814
Хээлтэгч	47	14.1	13.5	27.6	13.2	7948	104914
Бүгд						25637	280135

Дээрх хүснэгтээр тооцсон хонины махыг хонин толгойд шилжүүлвэл дараах томъёогоор тооцно.

$$T_x = \frac{A_{\text{Шмах}} + (A_{\text{Шмах}} * НГх)}{АЖэ/х} \quad (1.4)$$

T_x -хонины тоо,

$A_{\text{Шмах}}$ -махан ашиг,

$НГх$ -нядалгааны гарцыг өсгөх хэмжээ ($\frac{46}{100} = 0.46$),

$АЖэ/х$ = хонины амьдын жин /дунджаар/

$$T_x = \frac{280135 + (280135 * 0.46)}{52.2} = 7835.19$$

Хонины сүү бий болгох чадавхийг дараах хүснэгтээр тооцно.

Хүснэгт 8. Хонины сүү бий болгох чадавхийг тооцсон дүн

Хүйс	Тоо, толгой	Нэгжээс авах сүү /л/	Бүгд /л/
Эм хонь	7948	30	238440

Хонины ноос бий болгох чадавхийг дараах хүснэгтээр тооцно.

Хүснэгт 9. Хонины ноос бий болгох чадавхийг тооцсон дүн

№	Нас	Тоо, толгой	Нэгжээс авах ноос /кг/	Бүгд /кг/
1	1.5	5640	1	5640
2	2.5	3589	1.2	4306.8
3	3.5	8204	1.3	10665.2
4	Хээлтүүлэгч	256	1.7	435.2
5	Хээлтэгч	7948	1.5	11922
	Бүгд	25637		32969.2

Арьс нэхий, дайвар бүтээгдэхүүн (толгой, цувдай, өлөн) бий болгох чадавхи нь дээрх хүснэгтэнд тооцсон хонин толгой 25637 тэнцүү тооны байна. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг дараах хүснэгтээр тооцов.

Хүснэгт 10. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцсон дүн

Мах			Сүү			Ноос			Арьс			Дайвар бүтээгдэхүүн		
Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /л/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд
7835.19	4160	32594390.4	238440	1000	238440000	32969.2	500	16484600	25637	800	20509600	25637	2500	64092500
														372121090.4

Дээрх хүснэгтээс харахад Батширээт сум нь 141445.5 га бэлчээрийн газрын бүтээгч чадавхи 372121090.4 төгрөг болж байна. Эндээс 1 га бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээг дараах томъёогоор тооцож үзвэл

$$БЧга = \frac{БЧ}{S} = \frac{372121090.4 \text{ төг}}{141445.5 \text{ га}} = 2630.84 \text{ төгрөг}$$

2.2.3 Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох (Ямаан сүрэг)

Монголчууд эрт дээр үеэс өсгөн үржүүлж ирсэн таван хошуу малын нэг бол ямаан сүрэг төв Азийн цаг уурын нөхцөлд бэлчээрээр маллахад зохицсон, биологи аж ахуйн өвөрмөц онцлогтой, ялангуяа говь, цөлөрхөг хээр, уулархаг нутгийн бэлчээр чадамгай ашиглаж, хөнгөн, хүнсний үйлдвэрийн чухал түүхий эд бүтээдэг аж ахуй юм. Ямааны мах, ноолуур ба түүний сүүг өргөн ашигладаг. Сүүгээр нь бяслаг ба олон

төрлийн цагаан идээ хийнэ. Цагаан болон хар ямааны сүүг эмчилгээний зориулалтаар болон эмийн бэлдмэл хийхэд ашигладаг. Ямааны махны ашиг шимийг бий болгох боломжийг дараах томъёогоор бодож гаргана.

$$M_T = \frac{\left[\frac{AJ_T}{100} + (AJ_D - AJ_T) \right] HГ_T}{100} \quad (1.5)$$

M_T-Тухайн насны малын махны жилийн өсөлт буюу үйлдвэрлэгдэж буй махны хэмжээ

AЖ_Д-Дараах насны малын амьдын жин

AЖ_T-Тухайн насны малын амьдын жин

HГ-Тооцож буй малын нядалгааны гарц

Нядалгааны гарцыг дараах хүснэгтээр тооцно.

Хүснэгт 11. Нядалгааны гарц

№	Малын төрөл	Нядалгааны гарц, хувиар
1	Үхэр	55-65
2	Хонь, ямаа	44-48
3	Адуу	47-54
4	Тэмээ	55-65

Хүснэгт 12. Монгол ямааны махны гарц

Насны ялгаа	Амьдын жин /кг/	Гулуузны жин /кг/	Гарц /%/	Тухайн насны малын махны жилийн өсөлт
12 саргай	25.5	12.1	47.6	1.7
1.5 настай	28.9	13.4	49.6	2.5
2.5 настай	29.3	16.0	49.5	6.5
3.5 настай	34.0	19.1	49.1	7.5
4.5 настай	48.9	22.0	50.4	11.4
5.5 настай	71.0	38.8	54.6	

Хүснэгт 13. Ямаан сүргийн зохистой харьцаа

№	Нас	Сүрэгт эзлэх хувь	Бүгд
1	1.5	27	4054
2	2.5	10	1501
3	3.5	28	4204
4	Хээлтүүлэгч	0.5	75
5	Хээлтэгч	35	5179
	Бүгд	100	15013

Ямааны махыг бусад малын махны адил хүнсэнд хэрэглэдэг ба онцлог нь ямаа мах булчиндаа гадар өөх багатай, өөхөн сүүлгүй, харин дотор өөхний хуримтлал ихтэй, ямааны мах өөхний нядлагын гарц 40-45 хувь байдаг. Ямааны өлөн гэдэс хиамны үйлдвэрийн чухал түүхий эд болох ба эврээр нь жижиг сам, цаасны хутга зэрэг эдлэл, туурайгаар нь цавуу хийдэг байна. Ямааны ясаар янз бүрийн ясан эдлэл хийж болохоос гадна нунтаглаж малын

тэжээлийн хольц, газар тариалангийн сайн бордоо бэлтгэдэг. Ямааны маханд нийтдээ 15 нэрийн амин хүчил илэрсэн ба борог маханд агуулагдах үл орлогдох амин хүчлийн хэмжээ өөхтэй махныхаас харьцангуй их тодорхойлогдсон байна. Ямааны мах олон нэрийн хүчлээр баялаг, ханаагүй тосны хүчлийн агууламж өндөр (45.7-49.1%) төдийгүй уургийн үл орлогдох амин хүчил (44.0-39.0%) ихтэй чанартай мах хэмээн тодорхойлжээ (Л.Чой-Иш, 2005). Монгол ямаа бэлчээрээр таргалах чадвар сайтай бөгөөд намар бүдүүн ухна 55-58, эм ямаа 37-41, шүдлэн ухна 35-38, охин шүдлэн 29-31 кг жин дардаг. Ямааны махны ашиг шимийг бий болгох боломжийг тооцож гаргавал дараах байдалтай байна.

Хүснэгт 14. Ямааны махны ашиг шимийг бий болгох боломжийг тооцсон дүн

Нас	Амьдын жин	Гулуузны жин	Нядлагын		Малын нэмэгдэх махны хэмжээ /кг/	Малын тоо	Нийт нэмэгдэх махны хэмжээ /кг/
			жин	хувь			
1.5	36.9	16.0	18.3	47.6	1.7	4054	6892
2.5	42.9	19.1	21.1	49.6	2.5	1501	3753
3.5	48.9	22.0	24.7	49.5	7.5	4204	31530
Хээлтүүлэгч	52.2	24.7	26.9	49.1	11.4	75	855
Хээлтэгч	37.9	14.1	16.0	50.4	6.5	5179	33664
Бүгд						15013	76694

Дээрх хүснэгтээр тооцсон махыг ямаан толгойд шилжүүлвэл дараах томъёогоор тооцно.

$$T_x = \frac{A_{\text{Шмах}} + (A_{\text{Шмах}} * НГх)}{АЖэ/х} \quad (1.6)$$

T_x - ямааны тоо,

$A_{\text{Шмах}}$ - махан ашиг,

$НГх$ - нядалгааны гарцыг өсгөх хэмжээ ($\frac{46}{100} = 0.46$),

$АЖэ/х$ - ямааны амьдын жин /дунджаар/

$$T_x = \frac{76694 + (76694 * 0.46)}{43.8} = 2556.46$$

Ямааны сүүний ашиг шимийг Д.Цэрэнсодном нэлээд сайн судалж, говийн нөхцөлд ямааны саалын хугацаа 225 хоног үргэлжилж, 60-70 литр сүү саалгадаг, сүүний гарц саалийн эхэн үед бага, дунд үеэр ихсэж, сүүл үе рүүгээ дахин багасдаг, харин ямааны сүүний гарц зургаа, долдугаар саруудад ихсэж, дээд хэмжээндээ хүрэх ба хоногийн саам 108-412 гр, сарынх 3.24-12.36 литр хүрнэ. Эрдэмтэн Р.Индрагийн судалгаагаар говийн ямааны сүүний хуурай бодис 15.44-0.06 хувь, тос 5.81-0.03 хувь, нийт уураг 3.87-0.03 хувь,

лактоз 4.87-0.29 хувь, үнс 0.89-0.019 хувь байжээ. Ямааны саалийн хугацаа 7 сар үргэлжилж, 60-70 литр сүү өгдөг. Сүү ашиглах гол үе нь 6-р сарын 1-ээс 8-р дугаар сарын 15-ыг хүртэлх хугацаа бөгөөд ямаа бүрээс таваарын 20-30 литр сүү ашиглана. Ямааны сүү бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцно.

Хүснэгт 15. Ямааны сүү бий болгох чадавхийн үзүүлэлт

Хүйс	Тоо, толгой	Нэгжээс авах сүү /л/	Бүгд /л/
Эм ямаа	5179	25	129475

Ямаан сүргийн тархалт дэлхийн өргөн уудам нутгийг хамрах учир тухайн улс орны цаг агаарын эрс халуун эсвэл бүр сэрүүн байдлаас хамаарч ямаа элгэн халцгай эсвэл хэт ноосорхог, зарим нь ноолууртай байдаг. Нэг ямаанаас дунджаар 250 грамм ноолуур гардаг. Нэг грамм цэвэр ноолуураар 9-10 метр утас ээрдэг. Монгол улс нь дэлхийн нийт ноолуурын 35-40% гаруй хувийг бэлтгэдэг. Монгол ямааны ноолуурын ширхэгийн голч 13.0-16.5 мкм, дундаж урт 38-45 мм бөгөөд манай орны эрс тэс цаг ууртай холбогдон дулаан хадгалах чанараараа бусад орны ямааны ноолуураас давуу байдаг. Ямааны ноолууран бүтээгдэхүүн нь хөнгөн, уян зөөлөн, дулаан хадгалах болон хэлбэрээ хадгалах чадвар онцгой сайн, тансаг бүтээгдэхүүн бөгөөд зах зээлд байнгын эрэлт хэрэгцээтэй байдаг. Ухна 250-350, эм ямаа 240-270, борлон ухна 200-240, охин борлон 200-230, эр ямаа 240-380 грамм ноолуур өгдөг. Ямааны ноолуур бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцсон.

Хүснэгт 16. Ямааны ноолуур бий болгох чадавхийг тооцох үзүүлэлт

№	Нас	Тоо, толгой	Нэгжээс авах ноолуур /кг/	Бүгд /кг/
1	1.5	4054	0.19	770.26
2	2.5	1501	0.21	315.26
3	3.5	4204	0.30	1261.2
4	Хээлтүүлэгч	75	0.35	26.25
5	Хээлтэгч	5179	0.22	1139.38
Бүгд		15013		3512.35

Арьс нэхий, дайвар бүтээгдэхүүн (толгой, цувдай, өлөн) бий болгох чадавхи нь дээрх хүснэгтэнд тооцсон нийт ямаан сүргийн тоотой тэнцүү 15013 байна. 2016 оны эцсийн байдлаар Батширээт сумын нийт ямаан сүргийн ашиг шимийг мах, сүү, ноолуур, арьс, дайвар бүтээгдэхүүнээр тооцож үзэв. Бэлчээрийн газрын газрын бүтээгч чадавхийг дараах хүснэгтээр тооцов.

Хүснэгт 17. Бэлчээрийн газрын газрын бүтээгч чадавхийг тооцсон дүн

Мах			Сүү			Ноолуур			Арьс			Дайвар бүтээгдэхүүн			Бүгд дүн /төг/
Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /л/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	
2556.46	3900.0	9970194	129475	800.0	103580000	3512.35	55000.0	193179250	15013	8000.0	120104000	15013	1500.0	22519500	449352944

Дээрх хүснэгтээс харахад Батширээт сум нь 141445.5 га бэлчээрийн газрын бүтээгч чадавхи 449352944 төгрөг болж байна. Эндээс 1 га бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээг дараах томъёогоор тооцож үзвэл

$$\text{БЧга} = \frac{\text{БЧ}}{S} = \frac{449352944 \text{ төг}}{141445.5 \text{ га}} = 3176.86 \text{ төгрөг}$$

ГУРАВ. СУМЫН ГАЗРЫН ТОХИРОМЖТОЙ БОЛОН ХЭРЭГЦЭЭТ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

3.1 Сумын газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ

ГХГЗЗГ-ын даргын тушаалын 2015 оны 9-р сарын 9-ний өдрийн А/200 тоот Газрын тохиромжтой байдлын үнэлгээний аргагүй, шалгуур үзүүлэлтүүд батлах тухай тушаалд зааснаар Батширээт суманд бэлчээр, тариалан, хот суурин, ой, зам, шугам сүлжээ болон аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээг дараах шалгуур, аргачлалын дагуу хийсэн.

3.1.1 Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Тариалангийн газрын тохиромжтой байдлын иж бүрэн үнэлгээ”-г боловсруулсан. Тариаланд тохиромжтой газрын иж бүрэн үнэлгээ өгөхдөө хүрээлэн буй орчныг нэгдсэн систем гэж үзэж, байгаль болон нийгэм эдийн засгийн хүчин зүйлүүдийг хослуульж 5 шатлалтай ангиллаар үнэлгээний хүчин зүйлсийн үзүүлэлт бүрт тохируулан тогтоосон онооны (баллын) аргаар үнэлгээг боловсруулсан. Үүнд:

1. Геофизик хүчин зүйлийн үнэлгээ
 - 1.1. Газрын гадаргын үнэлгээ
 - 1.2. Гидрологийн үнэлгээ
 - 1.3. Инженер-геологийн үнэлгээ
 - 1.4. Хөрсний үнэлгээ
2. Уур амьсгалын үнэлгээ
 - 2.1. Агаарын температур
 - 2.2. Хур тунадас
 - 2.3. Дулаан хангамжийн нөхцөл
 - 2.4. Чийг хангамжийн нөхцөл
3. Газар ашиглалтын суурь нөхцлийн үнэлгээ
 - 3.1. Ой бүхий талбай
 - 3.2. Хот суурингийн газар
 - 3.3. Зам, шугам сүлжээний газар
 - 3.4. Тариалангийн талбай
 - 3.5. Уул уурхайн талбай
 - 3.6. Түүх соёлын дурсгалт газар
 - 3.7. Археологийн үнэт олдвор
 - 3.8. Гол, мөрөн

3.9. Булаг, худаг уст цэг

3.10. Манхан элс

Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийхэд тусгагдсан 3 үндсэн, 29 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэсэн.




График 3. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтийг үндэслэн үнэлгээ хийхэд Батширээт сумын хувьд газар тариаланд тохиромжтой 46037.40 га буюу 6.56 хувь, хязгаарлагдмал тохиромжтой 31368.08 га буюу 4.47 хувь, тохиромжгүй 7274.22 буюу 1.04 хувийг эзэлж байна.

Хүснэгт 18. Тариаланд тохиромжтой газрын хэмжээ, га

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	617257.29	87.92
Нэн тохиромжгүй	116.54	0.02
Тохиромжгүй	7274.22	1.04
Хязгаарлагдмал тохиромжтой	31368.08	4.47
Тохиромжтой	46037.40	6.56
Нийт талбай	702053.52	100.00





График 4. Тариалангийн газрын тохиромжтой байдлын эзлэх хувь



Зураг 2. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг

3.1.2 Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Тухайн орон нутаг, бүс нутгийн бэлчээрийн ургамлын анги, бүлэг төрөл, идэмж, байгалийн бүс бүслүүр, гадаргын нөхцөл, усан хангамж, бэлчээрийн хэв шинж зэрэг үзүүлэлтэд үндэслэн үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Хадлан, бэлчээрийн

газрын тохиромжтой байдлын үнэлгээ”-г боловсруулна. Хадлан, бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг бэлчээрийн ургамлын 250 анги, бүлэг төрлөөр 7 үндсэн үзүүлэлтэд үндэслэн гүйцэтгэсэн.



График 5. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний схем


Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтийг үндэслэн Батширээт сумын өвөл, хаврын бэлчээрийн хувьд адуунд нэн тохиромжтой 35460.87 га буюу 5.05 хувь, хонинд нэн тохиромжтой 17542.27 га буюу 2.5 хувь, үхэрт нэн тохиромжтой 75487.30 га буюу 10.75 хувь, ямаанд нэн тохиромжтой 17542.27 га буюу 2.5 хувь, тэмээнд нэн тохиромжтой бэлчээр байхгүй байна.


Хүснэгт 19. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /Өвөл-хавар/

Үнэлгээ	Адуу	Хонь	Тэмээ	Үхэр	Ямаа
Бусад	611935.70	611898.09	611859.34	611828.41	611898.09
Тохиромжгүй	6611.05	12709.77	14673.73	140.20	12709.77
Дунд зэрэг тохиромжтой	18032.79	13447.57	62891.83	12560.03	13447.57
Тохиромжтой	30013.11	46455.82	12628.62	2037.59	46455.82
Нэн тохиромжтой	35460.87	17542.27	0.00	75487.30	17542.27
Нийт талбай	702053.52	702053.52	702053.52	702053.52	702053.52


Хүснэгт 20. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /Өвөл-хавар/

Үнэлгээ	Адуу	Хонь	Тэмээ	Үхэр	Ямаа
Бусад	87.16	87.16	87.15	87.15	87.16
Тохиромжгүй	0.94	1.81	2.09	0.02	1.81
Дунд зэрэг тохиромжтой	2.57	1.92	8.96	1.79	1.92
Тохиромжтой	4.28	6.62	1.80	0.29	6.62
Нэн тохиромжтой	5.05	2.50	0.00	10.75	2.50


*График 6. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /Өвөл-хавар/*




Зураг 3. Өвөл-Хаврын улиралд адуунд тохирох бэлчээрийн зураг




Зураг 4. Өвөл-Хаврын улиралд хонинд тохирох бэлчээрийн зураг



Зураг 5. Өвөл-Хаврын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн зураг



Зураг 6. Өвөл-Хаврын улиралд үхэрт тохирох бэлчээрийн зураг



Зураг 7. Өвөл-Хаврын улиралд ямаанд тохирох бэлчээрийн зураг

Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтийг үндэслэн Батширээт сумын зун, намрын бэлчээрийн хувьд адуунд нэн тохиромжтой 76792.93 га буюу 10.94 хувь, хонинд нэн тохиромжтой 48456.67 га буюу 6.9 хувь, үхэрт нэн тохиромжтой 74625.33 га буюу 10.63 хувь, ямаанд нэн тохиромжтой 48456.67 га буюу 6.9 хувь, тэмээнд нэн тохиромжтой 13504.80 га буюу 1.92 хувь байна.

Хүснэгт 21. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /Зун-намар/

Үнэлгээ	Адуу	Хонь	Тэмээ	Үхэр	Ямаа
Бусад	611823.94	611975.03	611896.91	611837.80	611975.03
Тохиромжгүй	562.67	6486.47	7068.43	0.00	6486.47
Дунд зэрэг тохиромжтой	12138.22	6215.50	38116.21	12709.63	6215.50
Тохиромжтой	735.76	28919.84	31467.17	2880.76	28919.84
Нэн тохиромжтой	76792.93	48456.67	13504.80	74625.33	48456.67
Нийт талбай	702053.52	702053.52	702053.52	702053.52	702053.52

Хүснэгт 22. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /Зун-намар/

Үнэлгээ	Адуу	Хонь	Тэмээ	Үхэр	Ямаа
Бусад	87.15	87.17	87.16	87.15	87.17
Тохиромжгүй	0.08	0.92	1.01	0.00	0.92
Дунд зэрэг тохиромжтой	1.73	0.89	5.43	1.81	0.89
Тохиромжтой	0.10	4.12	4.48	0.41	4.12
Нэн тохиромжтой	10.94	6.90	1.92	10.63	6.90







График 7. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /Зун-намар/




Зураг 8. Зун-намрын улиралд адуунд тохирох бэлчээрийн зураг




Зураг 9. Зун-намрын улиралд хонинд тохирох бэлчээрийн зураг



Зураг 10. Зун-намрын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн зураг



Зураг 11. Зун-намрын улиралд үхэрт тохирох бэлчээрийн зураг



Зураг 12. Зун-намрын улиралд ямаанд тохирох бэлчээрийн зураг

3.1.3 Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Шинээр байгуулах хот суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийхэд шаардагдах хүчин зүйл, тэдгээрийн шалгуур үзүүлэлтийн талаар Монгол улсын зам тээвэр, барилга хот байгуулалтын яамны 2010 онд боловсруулсан “Хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар” (УББ 30-201-09)-г бүрэн тусгагдсан учраас энэхүү батлагдсан баримт бичгийг үндэслэн тохиромжтой байдлын үнэлгээг хийсэн. Үнэлгээг хийхдээ дээрх аргачилсан зааварт тусгагдсан 4 үндсэн, 43 дэд үзүүлэлтээс 3 үндсэн 19 дэд үзүүлэлтийг хэвээр үлдээж, 1 үндсэн, 16 дэд шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. Үүнд: Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, инженер геологийн нөхцөл, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Шинээр байгуулах хот суурины дэвсгэр газрын тохиромжтой байдлын иж бүрэн үнэлгээ”-г боловсруулна. Шинээр байгуулах хот суурины дэвсгэр газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийхэд дараах тусгагдсан 3 үндсэн, 35 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.




График 8. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ


Шинээр байгуулах хот, суурин газарт тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтийг үндэслэн үнэлгээ хийхэд Батширээт сумын хувьд хот сууринд тохиромжтой 75455.57 га буюу 10.75 хувь, хязгаарлагдмал тохиромжтой 7968.64 га буюу 1.14 хувь, тохиромжгүй 355.46 буюу 0.05 хувийг эзэлж байна.

Хүснэгт 23. Шинээр байгуулах хот, суурин газарт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	618274.06	88.07
Тохиромжгүй	355.44	0.05
Хязгаарлагдмал тохиромжтой	7968.44	1.14
Тохиромжтой	75455.57	10.75
Нийт талбай	702053.52	100



График 9. Шинээр байгуулах хот, суурин газарт тохиромжтой газрын эзлэх хувь



Зураг 13. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг

3.1.4 Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Байгалийн нөөц рекреацийн нутаг дэвсгэр ашиглалтын урьдчилсан нөхцөлүүдийн нэг гол хүчин зүйл, байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийн төдийгүй түүний иж бүрдлийг бүхэлд нь хамардаг онцлогтой юм. Батширээт сумын ландшафт-рекреацийн чадавхийн үнэлгээнд дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзэж шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Үүнд:

1. Ландшафтын үнэлгээ
 - 1.1. Газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээ
 - 1.2. Уур амьсгалын аялал-рекреацийн үнэлгээ
 - 1.3. Гадаргын ус- рашааны аялал-рекреацийн үнэлгээ
 - 1.4. Био нөөцийн аялал-рекреацийн үнэлгээ
 - 1.5. Ландшафтын гоо зүйн үнэлгээ
2. Байгаль, түүх, соёлын дурсгалт газрын үнэлгээ
 - 2.1. Байгаль-соёлын дурсгалт газар
 - 2.2. Түүх-соёлын дурсгалт газар
3. Дэд бүтцийн үнэлгээ
 - 3.1. Гатлага, зам (даваа, ус, элс, намаг, шавар, сөөгөн ширгэнэ)
 - 3.2. Хот болон байнгын оршин суух газарт ойрхон эсэх
 - 3.3. Тохижилтын түвшин
4. Газар ашиглалтын суурь нөхцөлийн үнэлгээ
 - 4.1. Тариалангийн талбай
 - 4.2. Одоо байгаа хот суурин газар
 - 4.3. Уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай
 - 4.4. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн онгон болон онцгой бүс

Тухайн орон нутаг, бүс нутгийн ландшафт, байгаль, түүх, соёлын дурсгалт, дэд бүтэц, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Байгалийн аялал- рекреацийг хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн үнэлгээ”-г боловсруулна.




График 10. Ландшафтын үнэлгээний схем

Хүснэгт 24. Аялал жуулчлалын газарт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	611869.75	87.15
Тохиромжгүй	900.32	0.13
Хязгаарлагдмал тохиромжтой	5582.57	0.80
Тохиромжтой	83700.87	11.92
Нийт талбай	702053.52	100.00

Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийхэд тохиромжтой газар 83700.87 га буюу 11.92 хувь, хязгаарлагдмал тохиромжтой 5582.57 га буюу 0.8 хувь, тохиромжгүй 900.35 буюу 0.13 хувь, бусад газар ашиглалт 611869.75 га буюу 87.15 хувийг эзэлж байна.





График 11. Аялал жуулчлалын газарт тохиромжтой газрын эзлэх хувь



Зураг 14. Аялал рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг

3.1.5 Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, инженер геологийн нөхцөл, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ

өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын үнэлгээ”-г боловсруулна.




График 12. Шугаман байгууламжийн тохиромжтой байдлын үнэлгээ

Авто замын газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийхэд хэвийн үнэлгээтэй газар 95031.03 га буюу 13.54 хувь, хүндрэлтэй 103472.81 га буюу 14.74 хувь, нэн хүндрэлтэй 503549.69 буюу 71.73 хувийг эзэлж байна.

Хүснэгт 25. Авто замд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

№	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Нэн хүндрэлтэй	503549.69	71.73
2	Хүндрэлтэй	103472.81	14.74
3	Хэвийн	95031.03	13.54
	Нийт талбай	702053.52	100.00





График 13. Авто замд тохиромжтой газрын талбайн эзлэх хувь




Зураг 15. Авто зам болон төмөр замын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг

Шугам сүлжээний газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийхэд хэвийн үнэлгээтэй газар 95151.82 га буюу 13.55 хувь, хүндрэлтэй 108528.43 га буюу 15.46 хувь, нэн хүндрэлтэй 498373.27 буюу 70.99 хувийг эзэлж байна.

Хүснэгт 26. Шугам сүлжээнд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

№	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Нэн хүндрэлтэй	498373.27	70.99
2	Хүндрэлтэй	108528.43	15.46
3	Хэвийн	95151.82	13.55
	Нийт талбай	702053.52	100.00



Зураг 16. Цахилгаан дамжуулах агаарын шугамын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг

Хуудас 48

3.1.6 Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Тухайн орон нутаг, бүс нутгийн ой-ургамалжилтын муж, өндрийн бүслүүр ангилалд тулгуурлан гадаргын нөхцөл, хөрсний шинж чанарыг илтгэх үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээ”-г боловсруулна.





График 14. Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээ

Ойн сан бүхий газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийхэд тохиромжтой газар 15383.39 га буюу 2.19 хувь, хязгаарлагдмал тохиромжтой 58216.51 га буюу 8.29 хувь, тохиромжгүй 16513.84 буюу 2.35 хувийг эзэлж байна.

Хүснэгт 27. Ойн санд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад	611939.77	87.16
Тохиромжгүй	16513.84	2.35
Хязгаарлагдмал тохиромжтой	58216.51	8.29
Тохиромжтой	15383.39	2.19
Нийт талбай	702053.52	100.00



Зураг 17. Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг

3.1.7 Хөв цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Хөв цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлыг тогтоохдоо байгалийн болон хүний хүчин зүйлийг харгалзан үздэг.


Байгалийн хүчин зүйл

1. Хонхор хотгор газрын хэмжээ
2. Гадаргын урсгалын чиглэл
3. Ус урсах талбай
4. Газрын хэвгий
5. Хөрсний ус нэвчиц
 - 5.1 Намагших буюу ус үл нэвчүүлэх гадарга-байгалийн тогтоц
 - 5.2 Инженерийн хийц ус үл нэвчүүлүүлэх гадарга үүсгэх
6. Хур тунадасны хэмжээ
7. Ууршиц
8. Урсацын модуль
9. Ойн сан

Хүний хүчин зүйл

1. Газар тариалан
2. Авто зам
3. Хот суурин
4. Уул уурхай
5. Газар ашиглалтын бусад хэлбэр зэрэг хүчин зүйлийг харгалзах өндрийн тоон загвар, гадаргын усны сүлжээ, газар тариалан, авто зам, хот суурин ойн сан, уул уурхай, засаг захиргааны нэгж, хөрс, байр зүйн зураг, хур тунадас, агаарын хэм, харьцангуй чийгшил зэрэг мэдээг ашиглан хөв цөөрөм байгуулах тохиромжтой байдлын үнэлгээг гаргалаа.

Хөв цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтээр тус суманд нийт 52649.24 га буюу нийт нутаг дэвсгэрийн 7.5 хувь хөв цөөрөмд тохиромжтой гэж гарсан.



Зураг 18. Хөв, цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг

3.1.8 Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Газар нутгийн хадгалан хамгаалах нь оршин тогтнох эх үндэс, хүмүүсийн амьдралыг тэтгэгч ус, цэвэр агаар, эрүүл орчинг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй билээ. Түүнчлэн биологийн төрөл зүйлийн нөөцийг тогтвортой, эрүүл байлгах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад бидний амьдарч буй орчин нөлөөлдөг. Иймээс эдгээр шинж чанарыг авч үлдэхийн тулд хадгалан хамгаалах зайлшгүй шаардлагатай. Хадгалан хамгаалах газрын үнэлгээ хийхдээ хамгаалах амьтан, ургамлын зүйлийг тодорхойлохоос эхэлдэг бөгөөд дараах аргыг хэрэглэдэг. Үүнд:

1. Амьдрах орчны хамгаалал болон газар нутгийг тусгай хамгаалалтанд авах, байгаль орчны төлөвлөгөө боловсруулах
2. Уул уурхай болон эрчим хүчний хөгжил тэдгээрийн нөлөөг бууруулах
3. Биологийн судалгаа болон хяналт шинжилгээ
4. Экосистемийн үйлчилгээний үнэлгээний хүрээнд бэлчээр болон усны нөөцийг тогтоох зэрэгт ашигладаг.


Амьтны тархацын зүйлийн загвар гаргахад дараах мэдээллийг ашиглана. Үүнд: Амьдрах орчны тодорхойлолт-тухайн зүйлийн амьдрах орчны физик шинж чанар болон хүрээлэн буй орчны тодорхойлолт

1. Ажиглалт судалгааны мэдээ
2. Идэж тэжээл
3. Өндөршил
4. Гадаргын хэлбэр
5. Экосистемийн ангилал
6. Хур тунадас зэрэг болно.

Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтээр тус суманд 267354.64 га буюу нийт нутаг дэвсгэрийн 38.08 хувийг хадгалан хамгаалахад тохиромжтой гэж гарсан.

Хүснэгт 28. Хадгалан хамгаалахад тохиромжтой газрын талбайн хэмжээ

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	434698.88	61.92
Хадгалан хамгаалахад тохиромжтой газар	267354.64	38.08
Нийт талбай	702053.52	100.00



Зураг 19. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг

СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө

Энэхүү төлөвлөгөөний чиг баримжаа нь Монгол улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн бодлого, аймгийн хөгжлийн бодлого, хөтөлбөртэй уялдсан болно. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн чиглэл бүрээр тодорхой тусгалаа.




График 15. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний үндсэн чиглэл


Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг газрын болон байгалийн нөөц нөхцөлд тулгуурлан дараах эрхзүйн баримт бичгүүдийг үндэслэн боловсруулсан. Үүнд:

- “Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргазүйн заавар” УБ, 2008 он
- Хэнтий аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тайлан
- “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” УБ, 2011 он
- Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм
- Монгол улсын стандарт MNS 4652-28
- Монгол улсын стандарт MNS 4628-98 “Шатахуун түгээх станц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага” УБ, 1998 он

- “Харилцаа холбооны тухай хууль”, засгийн газрын 2001 оны 263 дугаар тогтоол
- "Авто замын тухай хууль"-ийн 12.2 зүйл
- “Ойн тухай хууль” 2012 оны 5-р сарын 17
- “Аялал жуулчлалын тухай хууль” 2000 оны 5-р сарын 5

Батширээт сумын нутаг дэвсгэрийн нэгдсэн төлөвлөгөөг дараах зургаар харууллаа.

Газар ашиглалтын төрөл бүр дээр төлөвлөгөө гаргасан.



Зураг 20. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний зураг

4.2 Хамгаалалтын бүсийн төлөвлөгөө

Батширээт сумын газар нутагт гадаргын усны хамгаалалтын бүсүүд, зам шугам сүлжээний газрын хамгаалалтын бүсүүдийг тогтоож зохих газрын хэмжээг тооцоход 148507.86 га буюу 21.15%-ийг хамарч байна. Хамгаалалтын бүсийн 0.46%-ийг зам, шугам сүлжээний газрын хамгаалалтын бүс, 15.07%-ийг усны хамгаалалтын бүс эзэлж байна.

Хүснэгт 29.Хамгаалалтын бүсүүдийн норм, норматив

№	Барилга байгууламжийн төрөл	Хамгаалалтын бүсийн төрөл	Эрхзүйн баримт бичиг	Хамгаалалтын бүсийн өргөн, м
1	Голууд	Хориглох бүс	Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм	25
2	Голууд	Хязгаарлах бүс	Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм	50
3	Нуурууд	Хориглох бүс	Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм	25
4	Нуурууд	Хязгаарлах бүс	Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм	50
5	Худаг	Хамгаалалтын бүс	Монгол улсын стандарт MNS 4652-28	50
6	Шатахуун түгээх станц	Хамгаалалтын бүс	Монгол улсын стандарт MNS 4628-98	50
7	Өндөр хүчдэлийн шугам	Хамгаалалтын бүс	“Харилцаа холбооны тухай хууль”, Засгийн газрын 2001 оны 263 дугаар тогтоол	10
8	Улсын чанартай авто зам	Зурвас газар	"Авто замын тухай хууль"-ийн 12.2 зүйл	100
9	Орон нутгийн чанартай авто зам	Зурвас газар	"Авто замын тухай хууль"-ийн 12.2 зүйл	60

4.2.1 Усны хамгаалалтын бүс

“Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм”-д зааснаар гадаргын усны нөөцийг бохирдох хомсдохоос хамгаалах зорилгоор хориглох болон хязгаарлах бүсүүд тогтоох бөгөөд дараах зориулалтаар газар ашиглахыг хориглоно.

Хориглох бүсэд дараах зориулалтаар газар ашиглахыг хориглоно. Үүнд:

- Гол нуур цөөрөм, булгийн усыг хомсдуулж, ширгээх болон чанарыг нь муутган өөрчлөх нөлөөлөлтэй үйлдвэр, барилга байгууламж /цэвэрлэх байгууламж, нефть бааз, цахилгаан станц/ барьж ашиглах (энэ заалтанд зөвхөн ус хангамжийн төвлөрсөн системийн барилга байгууламжийг үл хамааруулна).

- Химийн хорт бодис, төрөл бүрийн бордоо, цацраг идэвхт бодис болон түүнийг агуулсан ашигт малтмал хадгалах, агуулах, халдварт өвчин тарааж болзошгүй барилга байгууламж байрлуулах

- Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газрыг ашиглах
- Барилгын карьер гаргах
- Гахай шувууны байр, саалийн механикжсан ферм, мал угаах цэг байршуулах.
- Автомашины шатахуун түгээх газар байгуулах, машин техник угаах, засварлах, бохир усны нүх, бие засах газар барих.
- Байгаль хамгаалах зохих арга хэмжээг авахгүйгээр амралт сувиллын газар байгуулах.

Хязгаарлах бүсэд дараах зориулалтаар газар ашиглахыг хориглоно. Үүнд:

- Гол нуур цөөрөм, булгийн усыг хомсдуулж, ширгээх болон чанарыг нь муутган өөрчлөх нөлөөлөлтэй үйлдвэр, барилга байгууламж /цэвэрлэх байгууламж, нефть бааз, цахилгаан станц/ барьж ашиглах (энэ заалтанд зөвхөн ус хангамжийн төвлөрсөн системийн барилга байгууламжийг үл хамааруулна).
- Химийн хорт бодис, төрөл бүрийн бордоо, цацраг идэвхт бодис болон түүнийг агуулсан ашигт малтмал хадгалах, агуулах, халдварт өвчин тарааж болзошгүй барилга байгууламж байрлуулах.
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газрыг ашиглах.
- Автомашины шатахуун түгээх газар байгуулах.

Шатахуун түгээх станцын хамгаалалтын бүсэд дараах зориулалтаар газар ашиглахыг хориглоно. Үүнд:

- Орон сууц, нийтийн үйлчилгээний газар
- Хүнсний үйлдвэрлэлийн объект
- Гэр хороолол
- Албан газрын барилга байгууламж.

Хүснэгт 30. Усны хамгаалалтын бүсүүдийн талбай

Д/д	Хамгаалалтын бүс	Хамгаалалтын бүсийн өргөн	Талбай, га
1	Булгийн онцгой хамгаалалтын бүс	50 м	25.13
2	Булгийн энгийн хамгаалалтын бүс	200 м	369.65
3	Нуурын онцгой хамгаалалтын бүс	100 м	231.64
4	Нуурын энгийн хамгаалалтын бүс	200 м	335.09
5	Худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс	50 м	231.64
6	Худгийн эрүүл ахуйн хязгаарлалтын бүс	200 м	335.09
7	Голын онцгой хамгаалалтын бүс	100 м	53889.77
8	Голын энгийн хамгаалалтын бүс	200 м	50344.32
Нийт			105796.75

4.2.2 Зам, шугам сүлжээний хамгаалалтын бүс

“Харилцаа, холбооны тухай хууль”-д зааснаар холбооны сүлжээнд зориулан олгосон хамгаалалтын зурвас газрын өргөн нь агаарын баганат шугамын хувьд 20 метр, кабелийн шугамын хувьд 10 метр байна. Холбооны мэдээлэл хүлээн авах станцын талбайн хэмжээг радио релейн шугамын станц хоорондын буюу сансрын холбооны хиймэл дагуулын газрын нэвтрүүлэх станцын долгион цацалтын орон зай, тухайн станцаас тал бүртээ 300 метрийн голчтойгоор, радио, телевизийн нэвтрүүлэх станцын болон долгион үүсгэх тоног төхөөрөмжийн хүчин чадлаас хамааруулан тогтоосон эрүүл ахуйн бүсээр авна.

Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын бүсийг Монгол улсын засгийн газрын 2001 оны 263 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасны дагуу авна.

Хамгаалалтын зурваст ажил, үйлчилгээ явуулах

- Хамгаалалтын зурваст инженерийн шугам сүлжээ барьж байгуулах, авто замын гарц гаргах, газар шорооны ажил гүйцэтгэхдээ эрчим хүчний шугам сүлжээний ашиглалтын байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.
- Хамгаалалтын зурваст эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн горим, ажиллагааг алдагдуулахаар үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглоно.
- Дулааны шугамд тусгай зориулалтын автомашин, механизмаар ажил, үйлчилгээ явуулах шаардлагын үүднээс түүний дээгүүр өнгөрөх цахилгаан болон холбооны агаарын шугамыг 10 м-ээс доошгүй өндөрт татсан байна.
- Эрчим хүчний шугам сүлжээг шилжүүлэх, түүнд өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага гарвал холбогдох зардлыг хүсэлт тавьсан байгууллага хариуцаж, шугам сүлжээний ашиглалт хариуцсан байгууллагын зөвшөөрлөөр түүний хяналтын дор гүйцэтгэнэ.
- Хамгаалалтын зурвас дотор газар дор байрласан инженерийн шугам сүлжээг ашиглагч байгууллага нь уг шугамын байршлын зураглалыг эрчим хүчний хангагч байгууллагад өгсөн байвал зохино.
- Хамгаалалтын зурваст газар шорооны ажил гүйцэтгэсний дараа хамгаалалтын зурвасын талбайг хэвийн байдалд нь оруулан сэргээнэ.


Хүснэгт 31. Зам, шугам сүлжээний газрын хамгаалалтын бүсийн талбай

Д/д	Хамгаалалтын бүс	Хамгаалалтын бүсийн өргөн	Талбай, га
1	Ердийн шороон зам	6 м	546.12
2	Холбооны шугамын хамгаалалтын зурвас	10 м	53.34
3	Эрчим хүчний шугамын хамгаалалтын зурвас	10 м	93.29
Нийт			692.75

4.2.3 Ойн хамгаалалтын бүс

Батширээт сумын хэмжээнд 554969.81 га газар ой модоор бүрхэгдсэн газар байна. Эдгээр модоор бүрхэгдсэн газрын ой нь хамгаалалтын бүсийн ой буюу 100 га хүртэлх ойд хамаарагдаж байна. Ойн ашиглалт, хамгаалалтад дараах шаардлага, нөхцөлийг хангаж ажиллах шаардлагатай. Хамгаалалтын бүс нь 42018.36 га буюу 5.99 хувийг эзэлж байна.

- Газрын нэгдмэл сангийн тооллогын аргачилсан зааврын дагуу сумын ойн сан бүхий газарт ойн захаас гадагш 100 м зурвас газар нь ой тэлэн ургах нөөц газарт бүртгэгддэг тул уг газарт бэлчээрээс бусад зориулалтаар газар ашиглахыг хориглоно.
- Хөрсийг усны эвдрэлээс хамгаалах, газрын доорх болон гадаргуугийн усны тэнцлийг хадгалах зорилгоор гол горхины эх, нуурын эргэн тойронд 5 км-ээс дотогш, голын эргээс хоёр тийш урсгалын дагуу, булаг шандын тархины эргэн тойрны 3 км доторх газарт хориотой бүсийн ойн хилийг татдаг бөгөөд тус сумын хувьд уг бүс нь хамгаалалтын бүсэд багтаж байна.
- Ойн нөхөн төлжилтийг хангах ойн захаас 100 метр хүртэлх зай болон ойн цоорхойд даацаас хэтэрсэн мал бэлчээх, сэлгээгүй хадлан бэлтгэх зэргээр ой мод байгалийн жамаар үрээ хаяж, нөхөн төлжих боломжийг алдагдуулахгүй байх, ашиглалтын явцад зохистой хэмжээний төлбөр ногдуулах арга хэмжээ авбал зохино.
- Ойн хөнөөлт шавьж хүр эрвээхэйн өндөг ихээр тархсан газруудад устгал хийх, ойгоос их хэмжээгээр мод огтлохгүй байх зэрэг нийтлэг арга хэмжээ авахаас гадна ойн ашиглалт болон хамгаалалтын бүсүүдэд ашиглалтын горимыг мөрдөнө.



Зураг 21. Хамгаалалтын бүсийн төлөвлөгөөний зураг

4.3 Хөдөө аж ахуйн газрын төлөвлөгөө

4.3.1 Бэлчээрийн газрын төлөвлөгөө

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тухайн нутгийн онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны газруудад хуваарилан багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж цаашид иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж ажиллах боломжтой тул бэлчээрийн газрыг хуваарилан төлөвлөгөөнд тусгалаа. Батширээт сумын хувьд 141445.5 га буюу нийт нутаг дэвсгэрийн 20.15 хувийн бэлчээрийн нөөцтэй байна. Үүнээс Норовлин багийн 3930.16 га бэлчээр нь хот тосгон бусад суурины газрын зориулалтаар хасагдсан.

Тус сумын нутгийн 137515.34 га буюу 19.59 хувийг бэлчээрийн газар эзэлдэг бөгөөд нүүдлийн бэлчээрийн уламжлалтай манай орны бусад сумуудтай харьцуулан үзэхэд хөдөө аж ахуйн газрын хэмжээ бага хэдий ч тэргүүлэх салбарын нэг билээ. Бэлчээрийн газарт нөлөөлөх хүчин зүйлүүдэд газарзүйн байрлал, газрын гадаргын хэв шинж, байгаль цаг уурын онцлогтой уялдуулан бэлчээрийн улирлын ашиглалтын байршлыг тогтоож зурагласан. Бэлчээрийн улирлын ашиглалтыг дараах төрлүүдэд хуваана. Үүнд:

1. Өвлийн бэлчээр—өвлийн улирал нь агаарын температур хамгийн хүйтэн, бэлчээрийн ургамлын шим муудаж, хагдарч унасан, цасанд дарагдсан, ил задгай усгүй болсон хамгийн ширүүн улирал юм. Иймд өвлийн бэлчээрээр салхи багатай

нөмөр нөөлөгтэй, нимгэн цас унадаг, үетэн ургамал зонхилсон, уул толгодын өвөр энгэр ээвэр болон дэрс буттай хотгор газрыг сонгоно.

2. Хаврын бэлчээр–Агаарын температур нэмэх градуст шилжиж дулаарах боловч огцом хүйтрэх, хүчтэй шуурга тавих зэрэг эрс тэс нөхцөл байнга тохиолдож мал төллөж эхэлддэг. Иймд малчид гарсан төлийг бойжуулахад онцгой анхаардаг учраас хаврын улирлын бэлчээр нь малыг салхинаас нөмөрлөсөн, цас түрүүлж хайлдаг энгэр ээвэр, чийг сайтай, зөөлөн хөрстэй, бууцнаасаа холгүй газрыг сонгоно.
3. Өвөл хаврын бэлчээр–Өвөл хаврын улиралд дараалан нутаглах боломжтой өвөл хаврын бэлчээрийн төрх, нөхцөлийг хангасан газрыг сонгоно.
4. Зун намрын бэлчээр–Зун намрын улиралд дараалан нутаглах боломжтой зун, намрын бэлчээрийн төрх, нөхцөлийг хангасан газрыг сонгоно.
5. Дөрвөн улирал буюу эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бэлчээр–Сүүлийн жилүүдэд төв суурин газарлуу шилжих хөдөлгөөн нэмэгдэж бэлчээрийн сэлгээ хийх нөөц хомсдсон, нөгөөтэйгүүр малчид нэг газраа төвхнөж, малчин өрх нэмэгдсэн зэрэг шалтгаанаас нэг доороо жил тойрон нутаглах болсон. Иймд дөрвөн улиралд ашиглах боломжтой нөхцөл бүрдсэн газрын сонгоно.
6. Бусад–алслагдсан болон худаг уст цэг байхгүйн улмаас ашиглагдахгүй байгаа бэлчээр юм.

Сумын бэлчээрийн хамгийн их хувь буюу 43.25 %-ийг өвлийн бэлчээр, 16.6 хувь буюу 22831.66 га зун-намрын бэлчээр, 20.3% буюу 27911.46 га өвөл-хаврын бэлчээр, 10.45 % буюу 14372.16 га хаврын бэлчээр, 9.4 % буюу 12924.03 га дөрвөн улирлын бэлчээр гэсэн сэлгээгээр ашигладгийг хээрийн хэмжилт судалгаа, тохиромжтой байдлын үнэлгээ, одоогийн ашиглалтын байдал, санал асуулга, хэлэлцүүлэг зэрэг олон хүчин зүйлийн хамаарлаар судлан тогтоолоо.

Хүснэгт 32. Сумын улирлын бэлчээрийн талбай, багаар

Багийн нэр	Улирлын хуваарь	Талбай, га	Хувь
Онон баг	Дөрвөн улирлын бэлчээр	6569.92	4.78
	Зун-намрын бэлчээр	4024.35	2.93
	Өвлийн бэлчээр	37358.60	27.17
Барх баг	Өвөл, хаврын бэлчээр	4428.89	3.22
	Дөрвөн улирлын бэлчээр	6354.11	4.62
	Зун-намрын бэлчээр	11567.48	8.41
	Өвлийн бэлчээр	16589.03	12.06
	Өвөл, хаврын бэлчээр	10458.83	7.61
Хурх баг	Хаврын бэлчээр	1183.82	0.86
	Зун-намрын бэлчээр	7239.83	5.26
	Өвлийн бэлчээр	5528.39	4.02
	Өвөл, хаврын бэлчээр	13023.73	9.47
	Хаврын бэлчээр	13188.34	9.59
	Нийт талбай	137515.34	100.00





График 16. Улирлын бэлчээрийн эзлэх хувь



Зураг 22. Улирлын бэлчээр ашиглалтын зураг


4.3.2 Бэлчээр усжуулалтын төлөвлөгөө

Гадаргын усны судалгааг гаргасны үндсэн дээр Батширээт сумын хэмжээнд усжуулагдсан нутаг 641937.34 га буюу 91.44 хувь нь бөгөөд харин усжуулах шаардлагатай бэлчээр 60116.18 га буюу 8.56 хувь байна. Иймээс бэлчээрийн усан хангамжийн хувьд усжуулалтын төлөвлөгөө нэн тэргүүнд шаардлагагүй бөгөөд хэрвээ шаардлагатай тохиолдолд дараах газар нутгийг усжуулан ашиглах боломжтой юм. Усжуулах шаардлагатай бэлчээрийн 38.44% буюу 23110.69 га бэлчээр нь Онон багт, 42.96% буюу 25823.35 га бэлчээр Барх багт, 18.6% буюу 11182.14 га бэлчээр Хурх багт байна.

Онон багийн Хайрхан уул, Дааганай уул, Цагаан Атха уул, Живхээстэйн амнаас зүүн урагшаа Бага мөөгт толгой, Далын хөтөл хүртэл, Баян-Өлзийт уулаас урагшаа Нүргэстэйн ам хүртэл, Барх багт Хөх чулуут уулаас зүүн урагшаа Гуагийн хяр хүртэл, Шар-Өндрийн овоот уулаас зүүн урагшаа Улаан чулуут уул, Их Өгөөж уулаас зүүн тийш, Будиртын горхи, Нарийн хөндийгөөс урагшаа Нарийн ам, Хурх багт Шар царамын нуруугаас зүүн урагш Их Барчин уул, Өлийн ам, Өргөн Банзат уулаас баруун тийш Буурал хамар уул, Харангаам, Хайр уулаас зүүн тийш Урт булгийн ам орчмын бэлчээрүүдийг усжуулах шаардлагатай байна.

Хүснэгт 33. Бэлчээр усжуулалтын судалгаа

Багийн нэр	Байршил	Усжуулагдах талбай, га
Хурх	Шар царамын нуруугаас зүүн урагш Их Барчин уул Өлийн ам Өргөн Банзат уулаас баруун тийш Буурал хамар уул Харангаам Хайр уулаас зүүн тийш Урт булгийн ам	11182.14
Барх	Хөх чулуут уулаас зүүн урагшаа Гуагийн хяр хүртэл Шар-Өндрийн овоот уулаас зүүн урагшаа Улаан чулуут уул Их Өгөөж уулаас зүүн тийш Будиртын горхи Нарийн хөндийгөөс урагшаа Нарийн ам	25823.35
Онон	Хайрхан уул, Дааганай уул, Цагаан Атха уул Живхээстэйн амнаас зүүн урагшаа Бага мөөгт толгой, Далын хөтөл хүртэл Баян-Өлзийт уулаас урагшаа Нүргэстэйн ам хүртэл	23110.69
	Нийт	60116.18




Зураг 23. Усжуулах бэлчээрийн төлөвлөгөөний зураг

4.3.3 Бэлчээрийн ашиглалтын хэсгийн төлөвлөгөө

Бэлчээрийн газар ашиглалт нь үндсэн газар ашиглалт бөгөөд цаашид бэлчээрийг өнө удаан хугацаанд тогтвортой ашиглахын тулд улирлын сэлгээг сайн хийх, бэлчээрийн даац багтаамжид тааруулж малаа өсгөх, хамгаалах, тордох, эзэнтэй болгох, нөхөн сэргээдэг байх шаардлагатай. Иймд бид энэхүү нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд бэлчээр ашиглалтын хэсэг гэсэн бэлчээр ашиглалтын хэлбэрийг тогтоож төлөвлөгөөнд тусгасан. Энэхүү бэлчээр ашиглалтын хэсгийг малчдын санал дээр тулгуурлан тогтоосон ба багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлсэн. Батширээт сумын хэмжээнд бэлчээр ашиглалтын 8 хэсгийг тогтоож, энэхүү төлөвлөгөөнд тусгасан ба хэсэг бүрт багтах малчдын байршлын тоог доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 34. Бэлчээр ашиглалтын хэсгийн малчдын улирлын байршил

№	Багийн нэр	Бэлчээр ашиглалтын хэсэг	Талбай, га	Нийт малын тоо	Өвөлжөө (1)	Хаваржаа (2)	Өвөлжөө, хаваржаа (3)	Зуслан (4)	Намаржаа (5)	Зуслан, намаржаа (6)	4 улирал (7)	Хаваржаа, намаржаа (8)	Өвөлжөө, хаваржаа, намаржаа (9)	Хаваржаа, зуслан, намаржаа (10)
1	Хурх	Навчит	37653.4	47991.8	34	27	9		1	4	9		1	
2	Хурх	Баянгол	40784.0	34257.1	28	13	12		1	2	2	1	1	1
3	Онон	Дал	24690.5	36210.4	27	7	1	9			1	12	9	1
4	Онон	Арангагай	18647.8	16312.7	17	1	11					3	11	1
5	Онон	Хаслиг	48876.1	27107.5	28	1		6			8	8	10	5
6	Барх	Эг	14816.4	8056.2	6	6	3				2		11	
7	Барх	Шар нуга	19815.6	19652.7	6	8	4	4	1	4	1		11	1
8	Барх	Хайрхан	53914.1	50069.3	27	12	2	2	1	2	2	8	12	
Нийт			259198.0	239657.7	173	75	42	21	4	12	25	32	66	9



Зураг 24. Бэлчээр ашиглалтын хэсгийн төлөвлөгөөний зураг

Бэлчээрийг гэрээгээр ашиглах нь: Газрын тухай хуулийн 52.2-т заасан “Өвөлжөө, хаваржааны тодорхой бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, даац, чадавхийг харгалзан,

багийн иргэдийн нийтийн хурлын саналыг үндэслэн сумын засаг дарга малчдад болзол гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж болно” гэсэн заалтын дагуу бид гэрээгээр бэлчээрээ ашиглах боломжтой малчдын хуваарийг гаргаж төлөвлөгөөнд тусгав.

Батширээт сумын хэмжээнд тогтоосон өвөлжөө, хаваржааны бэлчээрийг хэсэгт хувааснаар цаашид малчин өрхүүд нэгдэж бүлэг, хэсэг байгуулан энэхүү хуваарийг хэлэлцэн тохиролцож бэлчээрийн газраа гэрээгээр зүй ёсны эрхийг баталгаажуулан ашиглаж болно. 2016 оны жилийн эцсийн малыг тоог хонин толгойгоор төлөвлөсөн 8 хэсэгт бэлчээрийн даацыг гаргасан. Бэлчээр ашиглалтын хэсгийн даацыг авч үзвэл бэлчээр ашиглалтын хэсгүүдийн даац хэтэрсэн байна. Хамгийн их бэлчээрийн даац хэтрэлттэй байгаа хэсэг нь Онон багийн Дал 8.14 дахин, Хаслиг 5.36 дахин хэтэрсэн байна. Мөн Барх багийн Хайрхан бэлчээрийн хэсэг 6.3 дахин, Хурх багийн Навчит 3.81 дахин, Баянгол 3.51 дахин хэтэрсэн байна. Онон багийн Арангатай хэсгийн бэлчээр 3.21 дахин, Барх багийн Шар нуга 2.38 дахин, Эг 1.85 дахин даац хэтрэлттэй байна.

Хүснэгт 35. Бэлчээр ашиглалтын хэсгийн даац

№	Багийн нэр	Бэлчээр ашиглалтын хэсэг	Бэлчээрийн талбай, га	БАХ, талбай	Хонин толгой, нийт	Га-ийн ургац, цн	Тэжээлийн нөөц, цн	Хонь жилд идэх өвс, цн	Багтаамж, хонин толгой	Даац, хувь
1	Онон	Хаслиг	12112.87	48876.1	27108	2.5	30349.5	6	5058	5.36
2	Онон	Дал	10404.95	24690.5	36210	2.6	26700.7	6	4450	8.14
3	Онон	Арангатай	8666.64	18647.8	16313	3.5	30525.8	6	5088	3.21
4	Барх	Эг	7909.63	14816.4	8056	3.3	26134.7	6	4356	1.85
5	Барх	Шар нуга	11185.64	19815.6	19653	4.4	49552.4	6	8259	2.38
6	Барх	Хайрхан	15757.15	53914.1	50069	3.0	47649.6	6	7942	6.30
7	Хурх	Баянгол	16373.64	40784.0	34257	3.6	58514.2	6	9752	3.51
8	Хурх	Навчит	22393.47	37653.4	47992	3.4	75651.0	6	12608	3.81

Бэлчээр ашиглалтын хэсэгт байгаа өрхүүд бэлчээрийн сэлгээг тогтсон цагт товлон хэсгийн ахлагч нарыг багийн иргэдийн нийтийн хурлаар шийдвэрлэх боломжтой. Иймд цаашид бэлчээрийн даацыг багтаамжид тааруулан бэлчээрийг гэрээгээр ашиглах нь зүйтэй.

Хүснэгт 36. Бэлчээр ашиглалтын хэсгийн багтаамж

№	Багийн нэр	Бэлчээр ашиглалтын хэсэг	Улирлын бэлчээр	Талбай, га	Га-ийн ургац, цн	Тэжээлийн нөөц, цн	Хонь жилд идэх өвс, цн	Багтаамж, хонин толгой
1	Хурх	Навчит		22393.47	3.38	75689.93	6.00	12614.99
			Өвөл, хаврын бэлчээр	5297.53	2.75	14568.22	5.40	2697.82
			Өвлийн бэлчээр	5526.34	2.65	14644.79	5.40	2712.00
			Зун-намрын бэлчээр	7111.64	5.56	39540.71	6.50	6083.19

			Хаврын бэлчээр	4457.96	3.30	14711.27	6.50	2263.27
2	Хурх	Баянгол		16373.64	3.57	58514.21	6.00	9752.37
			Зун-намрын бэлчээр	31.96	3.95	126.25	6.50	19.42
			Өвлийн бэлчээр	1.97	5.50	10.85	5.40	2.01
			Өвөл, хаврын бэлчээр	640.08	3.03	1936.23	5.40	358.56
			Хаврын бэлчээр	8658.80	4.55	39397.53	6.50	6061.16
3	Онон	Дал		10404.95	2.57	26700.70	6.00	4450.12
			4-н улирлын бэлчээр	50.65	2.50	126.63	5.40	23.45
			Зун-намрын бэлчээр	76.47	2.63	201.37	6.50	30.98
			Өвлийн бэлчээр	5881.55	2.52	14796.74	5.40	2740.14
			Өвөл, хаврын бэлчээр	4396.27	2.64	11621.45	5.40	2152.12
4	Онон	Арангатай		8666.64	3.52	30525.82	6.00	5087.64
			Зун-намрын бэлчээр	714.90	3.90	2788.10	6.50	428.94
			Өвлийн бэлчээр	7951.74	3.41	27149.52	5.40	5027.69
5	Онон	Хаслиг		12112.87	2.51	30349.47	6.00	5058.24
			Өвлийн бэлчээр	4162.04	2.49	10380.62	5.40	1922.34
			Зун-намрын бэлчээр	3237.75	2.90	9389.46	6.50	1444.53
			4-н улирлын бэлчээр	4713.08	2.50	11782.70	5.40	2181.98
6	Барх	Эг		7909.63	3.30	26134.74	6.00	4355.79
			Зун-намрын бэлчээр	3509.58	4.90	17196.95	6.50	2645.69
			Өвөл, хаврын бэлчээр	2223.57	3.12	6930.12	5.40	1283.36
			Хаврын бэлчээр	187.15	3.10	580.17	6.50	89.26
			Дөрвөн улирлын бэлчээр	1989.33	4.03	8023.63	5.40	1485.86
7	Барх	Шар нуга		11185.64	4.43	49552.37	6.00	8258.73
			Дөрвөн улирлын бэлчээр	1930.43	2.90	5598.26	5.40	1036.71
			Зун-намрын бэлчээр	6146.14	4.27	26223.51	6.50	4034.39
			Өвлийн бэлчээр	1879.28	5.05	9490.37	5.40	1757.48
			Өвөл, хаврын бэлчээр	309.43	2.90	897.33	5.40	166.17
			Хаврын бэлчээр	920.36	5.50	5061.97	6.50	778.76
8	Барх	Хайрхан		15757.15	3.02	47649.62	6.00	7941.60
			Дөрвөн улирлын бэлчээр	2433.69	3.43	8355.68	5.40	1547.35
			Зун-намрын бэлчээр	1324.23	4.87	6444.59	6.50	991.48
			Өвлийн бэлчээр	6725.53	2.81	18885.29	5.40	3497.28
			Өвөл, хаврын бэлчээр	5197.11	3.21	16704.98	5.40	3093.52


		Хаврын бэлчээр	76.59	3.10	237.43	6.50	36.53
--	--	----------------	-------	------	--------	------	-------

4.3.4 Хадлангийн газрын төлөвлөгөө

Сумын хэмжээнд шинээр хадлан эрхлэхэд боломжтой хөрс, ургамлан нөмрөг бүхий газрууд тохиромжтой байдлын үнэлгээгээр тодорхойлогдсон. Мөн хээрийн хэмжилт судалгаа, иргэдийн санал, орон нутгийн мэргэжилтэн удирдлагуудын санал хэлэлцүүлгийг үндэслэн 12 байршилд 4149.64 га талбайг сумын хадлангийн газраар сонгон төлөвлөлөө. Төлөвлөсөн 12 байршил нь Онон багт Богины ам, Урд Жаргалант толгой, Цахирт ам, Далын гол, Онон голд 966.74 га талбай, Барх багт Ламтын ам, Будиртын гол, Хадат толгой, Дунд булгийн аманд 1108.63 га талбай, Хурх багийн Навчийн гол, Хажуу нуурт 2074. 27 га талбайд төлөвлөсөн.

Хүснэгт 37. Хадлангийн газрын төлөвлөгөө


№	Багийн нэр	Газрын нэр	Талбай, га
1	Онон баг	Богины ам	160.99
2		Урд Жаргалант толгой	379.99
3		Цахиурт ам	79.77
4		Далын гол	262.09
5		Онон гол	83.90
6	Барх баг	Ламтын ам	134.47
7		Будиртын гол	115.08
8		Хадат толгой	663.42
9		Дунд булгийн ам	195.66
10	Хурх баг	Навчийн гол	1272.33
11		Хажуу нуур	438.72
12			363.22
	Нийт талбай		4149.64



Зураг 25. Хадлангийн газрын төлөвлөгөөний зураг

4.4. Хот тосгон бусад суурин газрын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө

Батширээт сумын хот тосгон бусад суурин газрын 8167.9 га талбайг дахин төлөвлөсөн. Дахин төлөвлөлтөөр гэр хорооллын бүс 12.98 % буюу 1060.35 га, дунд давхрын орон сууцны бүс 3.50 % буюу 285.57 га, олон нийт, ажил хэргийн төв бүс 6.0 % буюу 489.99 га, үйлчилгээний төрөлжсөн бүс 7.06 % буюу 576.8 га, үйлдвэрийн бүс 13.33% буюу 1088.53 га, ногоон байгууламж болон ногоон бүс 1.27 % буюу 103.37 га, эрчимжсэн аж ахуйн бүс 13.16 % буюу 1074.51 га, нөөц газрын бүс 25.73 % буюу 2101.67 га, зам харилцааны бүс 5.9% буюу 482.01 га, чөлөөт ашиглалтын бүс 11.08 % буюу 905.1 га талбайг төлөвлөсөн.



Зураг 26. Хот, суурин газрын функциональ бүсийн төлөвлөлтийн зураг

4.4.1 Аялал жуулчлалын газрын төлөвлөгөө, маршрут

Батширээт сум нь Хилчин даваа, Сонгинот байц, Нарстай хавтгай, Рашаантын зоо зэрэг байгалийн үзэсгэлэнт газар, Биндэр овоо, Рашаан хад, Чингисийн хэрэм, Буган хөшөө, Үзүүр цохио, Баянголын хүн чулуун хөшөө зэрэг түүх соёлын олон дурсгалт газартай. Сумын хэмжээнд одоогийн байдлаар аялал жуулчлалыг төдийлөн сайн хөгжүүлээгүй хэдийч аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой түүх дурсгал, уламжлалт соёл, байгалийн

тогтоц, унаган төрх байдал зэрэг газруудыг хамруулан аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх шаардлагатай байна.

Иймээс аялал рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээнд суурилан сумын иргэд, олон нийтийн санал, хэлэлцүүлгээс аялал жуулчлалын маршрутыг төлөвлөсөн. Сумын хэмжээнд 278.66 орчим км аялалын 3 маршрутын төлөвлөв. Үүнд: Сумын төвөөс Хилчин даваа хүртэл 118.01 км, сумын төвөөс Сонгинот байц хүртэл 80.26 км, сумын төвөөс Рашаан хад хүртэл 80.39 км аялал жуулчлалын маршрутыг төлөвлөсөн. Тухайн маршрутаар байгалийн үзэсгэлэнт газрууд болон түүх соёлын дурсгалт газруудыг үзэж сонирхох бөгөөд сумын онцлог сайхан газруудаар аялаж амрах боломжтой юм.

Хүснэгт 38. Аялал жуулчлалын маршрут

Аяллын маршрут	Урт, км
Маршрут 1. Сумын төвөөс Хилчин даваа	118.01
Маршрут 2. Сумын төвөөс Сонгинот байц	80.26
Маршрут 3. Сумын төвөөс Рашаан хад	80.39
Нийт	278.66





График 17. Аялал жуулчлалын маршрут



Зураг 27. Аялал жуулчлалын газрын төлөвлөгөөний зураг

4.5 Зам, шугам сүлжээний газрын төлөвлөгөө

4.5.1 Шинээр байгуулах хатуу хучилттай болон сайжруулсан авто замын газрын төлөвлөгөө

Хэнтий аймгийн Батширээт сум нь Улаанбаатар хотоос 413 км, аймгийн төв Чингис хотоос 186 км зайтай оршдог. Аймгийн төвтэй хээрийн шороон замаар холбогддог бөгөөд зам дэд бүтцийн хувьд сайжруулан хатуу хучилттай замтай болох нь иргэдийн зайлшгүй шаардлага болоод байна. Уг төлөвлөгөөнд аймгийн төвийг Батширээт сумтай, мөн багийн төвүүдийг сумын төвтэй холбох 258.03 км замыг төлөвлөсөн. Үүнд: Норовлин багийг Онон багийн төвтэй холбосон хатуу хучилттай зам 24.17 км, Норовлин багийг Барх багийн төвтэй холбосон хатуу хучилттай зам 2.6 км, Норовлин багийг Хурх багийн төвтэй холбосон хатуу хучилттай зам 45.26 км замыг төмөр зам болон авто замын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээнд тулгуурлан иргэдийн санал, хэлэлцүүлгийг үндэслэн төлөвлөсөн. Замыг бариж байгуулах тохиолдолд мэргэжлийн хэмжилт зураглалыг хийлгэх шаардлагатай.

Хүснэгт 39. Шинээр байгуулах замын төлөвлөгөө

№	Сумын төв	Чиглэл	Төлөвлөсөн замын урт, км
1	Норовлин	Онон	24.17
2	Норовлин	Барх	2.60
3	Норовлин	Хурх	45.26


4.5.2. Засах зам гүүр, даваа, бартаатай авто замын газрын төлөвлөгөө

Батширээт сум нь бүхэлдээ Онон голын ай сав газар багтана. Онон гол нь Хэнтийн нурууны зүүн хойд хажуугийн Ононгийн халуун рашааны орчмоос эх авах бөгөөд нийт 808 км урт, 94040 км² ус хурах талбайтай, үүний 575 км урт, 29070 км² талбай нь Монголын нутагт оршино. Голын сав газарт нийтдээ 166 гол горхи, 47 нуур цөөрөм байдаг (2007 оны тооллого). Онон гол нь уулын гол тул уналт ихтэй, урсгал хурдтай байдаг. Зарим газраа урсгалын хурд 1.5-2.0 м/с хүрэх боловч Балжийн бэлчирээс доош 1.0 м/с орчим болж буурна. Онон голын томоохон цутгал Агац, Балж, Эг, Барх, Жаргалант голууд нь эгц налуу хажуу бүхий уулархаг газраар урсдаг. Өнөөгийн байдлаар Онон болон түүний цутгал голууд болох Хурх, Эг, Барх болон Балж гол дээр ус судлалын 5 харуул, Гурван нуурын харуул зэрэг нийтдээ 7 ус судлалын харуул ажиллаж байна. Цаашид ч Онон голын зарим томоохон цутгал голууд дээр ус судлалын харуулуудыг байгуулах шаардлагатай. Түүний цутгал голын хувьд олон жилийн дундаж өнгөрөлт нь 1.5-12.6 м³ /сек хэлбэлзэнэ.

Мал аж ахуй болон нүүдлийн бэлчээрийн сэлгээ хийхэд гол гатлах гүүрний хэрэгцээ шаардлага их байна. Үүнийг үндэслэн Батширээт сумын Онон багт гүүр гарамыг төлөвлөлөө.

Хүснэгт 40. Гүүрийн төлөвлөгөө, байршил

№	Багийн нэр	Газрын нэр	Өргөрөг	Уртгаг
1	Онон баг	Онон гол	48° 53' 52.99" N	110° 06' 14.93" E



Зураг 28. Авто замын газрын төлөвлөгөөний зураг

4.5.3. Шинээр байгуулах эрчим хүчний шугамын газрын төлөвлөгөө

Батширээт сум нь зүүн бүсийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон ба суманд байнгын эх үүсвэртэй цахилгаан станц байдаг. Сумын төв эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон хэдий ч Онон, Барх, Хурх багууд эрчим хүчний шугамд холбогдоогүй байна. Батширээт сумаас Онон багийн төв хүртэл 24.17 км, Норовлин багийн төвөөс Барх багийн төв хүртэл 2.6 км, Норовлин багийн төвөөс Хурх багийн төв хүртэл 45.26 км эрчим хүчний шугамыг төлөвлөсөн. Төлөвлөсөн шугамын газрыг тохиромжтой байдлын үнэлгээний хэвийн гэсэн үзүүлэлттэй газруудыг сонгон төлөвлөсөн бөгөөд барилга байгууламжийн ажил хийгдэхээс өмнө нарийвчилсан хэмжилт зураглал хийлгэх шаардлагатай. Хэнтий аймаг нь ойрын хугацаанд Барх багийн төв буюу Монгол толгойг өндөр хүчдэлд холбохоор ажиллаж байна.

Хүснэгт 41. Шинээр байгуулах эрчим хүчний шугамын төлөвлөгөө

№	Сумын төв	Чиглэл	Төлөвлөсөн шугамын урт, км
1	Норовлин	Онон	24.17
2	Норовлин	Барх	2.60
3	Норовлин	Хурх	45.26

4.6 Зүй ёсны эрхээр ашиглах нутаг дэвсгэрийн төлөвлөгөө

Газрын харилцаа, Геодези, Зурагзүйн газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 21 өдрийн А/22 дугаар тушаалаар батлагдсан “Газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийг зориулалтаар нь бүртгэн, баталгаажуулах түр заавар”-ын дагуу зүй ёсны эрхээр баталгаажуулах төлөвлөгөөг хийсэн.

Зүй ёсны эрх гэж уламжлалт мал аж ахуйд голлон түшиглэж тухайн нутаг дэвсгэр дэх байгалийн бүхий л төрлийн нөөцийг түүний нөхцөлд дасан зохицож, арвижуулан, өсгөж, хамгаалж зүй зохистойгоор хэрэглэж ирсэн хараахан баталгаажуулаагүй байгаа уламжлалт эрх, албан бус эрх (төрийн болон иргэдийн хэрэглэж буй эрхүүд), тэдгээрийн дагалдах эрхүүдийг ойлгоно.

Батширээт сумын хэмжээнд байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрх үүсэж түүнийг баталгаажуулах боломжтой төрлүүд нь


1. Бэлчээрийн нөөцийг ашиглах, хамгаалах: Батширээт сум нь уламжлалт мал аж ахуй эрхэлдэг бөгөөд албан ёсоор баталгаажсан малчдын бүлэг, нөхөрлөл, хэсэг байхгүй ч, ой хамгаалах нөхөрлөл байна. Иймд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгасан бэлчээр ашиглалтын 8 хэсгийг түшиглэн уг эрхийг баталгаажуулах боломжтой юм. Тус бэлчээр ашиглалтын 8 хэсэг нь уламжлалт мал аж ахуйгаа эрхлэхийн зэрэгцээ өөрийн

бэлчээр нутгийн орчмын байгалийн бүхий л төрлийн нөөцийг хамгаалж, түүнд дасан зохицож, арвижуулан өсгөж, зүй зохистойгоор хэрэглэн зүй ёсны эрхээ баталгаажуулах юм. Зүй ёсны эрхийг баталгаажуулахдаа “Газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийг зориулалтаар нь бүртгэн, баталгаажуулах гэрээ”-г зүй ёсны эрх эдлэгч ба мэргэжлийн багийн хамт байгуулна.

2. Хадлан хашиж хамгаалах, бэлтгэх: Сумын хэмжээнд хадлан хадах томоохон талбай байхгүй бөгөөд айл өрхүүд өвөлжөө хаваржааны ойролцоох багахан хэмжээний газраас хадлан бэтгэдэг. Төлөвлөлтөөр 12 байршилд 4149.64 га талбайг төлөвлөсөн бөгөөд хамгаалах боломжтой юм.
3. Гол горхи, булаг шанд, нуур цөөрмийн усны ундаргыг хамгаалах, худаг, уст цэг ашиглах: Тус сумын нутагт 110 гадаргын уст цэг тоологдсон бөгөөд үүний 26 булаг, 68 худаг үүнийг хашиж хамгаалж зүй ёсны эрх эдлэх боломжтой.
4. Хөв, цөөрөм байгуулах, ашиглах: Нутгийн баруун, зүүн, хойд хэсэгт хөв цөөрөм байгуулахад тохиромжтой 176 байршил байдаг. Хөв цөөрөм байгуулснаар шар усны үерийг тогтоож, задгай ус бий болсноор зэрлэг ан амьтдын ундны ус болно.
5. Ан амьтан хамгаалах, ашиглах: Тус сумын нутагт ховор болон ховордож байгаан ан амьтад их тул түүнийг хамгаалж өсгөх шаардлагатай.
6. Байгалийн ургамлыг тарьж ургуулах
7. Эмийн ургамал түүх, хамгаалах: Эмийн болон ховор ургамал ихтэй нутаг тул түүнийг хамгаалах, мөн зохистой хэмжээнд түүх хэрэгтэй.
8. Ойн дагалт нөөц ашиглах, хамгаалах: Ойн нөхөрлөл байгуулж, ойг гэрээгээр эзэмшиж дагалдах баялгийг ашиглана.
9. Аялал жуулчлал эрхлэх: Сумын нутаг нь түүх соёлын дурсгалт газар болон байгалийн үзэсгэлэнт газартай.
10. Эрчимжсэн аж ахуй эрхлэх
11. Үйлдвэр, үйлчилгээг төрөлжүүлэн эрхлэх
12. Орон нутгийн онцлогоос хамаарсан бусад эрхүүд байна.

Дээрх зүй ёсны эрхийг тус сумын нутагт баталгаажуулах боломжтой юм. Иймээс зүй ёсны эрх эдлэгч нь мэргэжлийн багтай гэрээ байгуулж түүнийг баталгаажуулна. Мэргэжлийн баг гэж газар, байгалийн нөөцийг ашиглан хамгаалах хадлан бэлчээр ашиглуулах, хамгаалах зэрэг иргэдийг зүй ёсны эрх эдлэхэд нь зөвлөх туслах, хянах үүрэг бүхий сумын засаг даргын зүгээс томилсон орон нутгийн мэргэжилтнүүдийг хэлнэ. Үүнд газрын даамал, байгаль орчны байцаагч, ХАА-н мэргэжилтэн, байгаль хамгаалагч, багийн засаг дарга гэх мэт. Зүй ёсны эрх эдлэгч гэж иргэд, малчид, малчдын бүлэг, хот айл,

нөхөрлөл, хоршоод, аж ахуй нэгж байгууллага, төрийн бус байгууллага болон иргэд хоорондоо сайн дурын үндсэн дээр нэгдэж, зохион байгуулалтанд орсон бусад хэлбэрийн нэгдлүүдийг хэлнэ.



Зураг 29. Зүй ёсны эрхээр баталгаажуулах төлөвлөгөө

ДҮГНЭЛТ

Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө нь сумын хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох үндсэн баримт бичиг болно. Энэхүү төлөвлөгөөг боловсруулахад орон нутгийн иргэд, засаг газрын тамгын газрын бүрэлдэхүүн болон сумын иргэдийн төлөөлөгчид идэвхтэй оролцож сумын хөгжлийн чиг хандлагаа тодорхойлон баталгаажуулж авлаа. Иймээс сумын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа сумын нутаг дэвсгэрийн суурь судалгааны болон сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний баримт бичигт тусгасан төлөвлөгөөг барьж ажиллах шаардлагатай байна.

Сумын суурь судалгааны ажлыг зохион байгуулан хийж судалгаа хийсний үндсэн дээр сумын газрын тохиромжтой байдлын үнэлгээг газар ашиглалтын төрөл бүрээр хийж нутаг дэвсгэрийг зөв зохистой ашиглах, төлөвлөх боломжийг бий болгож өглөө. Тохиромжтой гэж үзсэн ангилал тус бүрт цаашид тохиромжтой ангилал бүрээр газрыг ашиглах хэрэгцээтэй байна.

Сумын хэрэгцээт байдлын үнэлгээг сумын иргэдээс авсан бөгөөд эдгээр иргэдийн санал газар ашиглахад тохиромжтой байна уу гэдэг нь тохиромжтой байдлын үнэлгээгээр тодорхой харагдах учир жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхэд ч нэг шат ахиж байна. Иймээс энэхүү баримт бичгийг ашиглах зайлшгүй шаардлагатай.

Энэхүү баримт бичиг нь сумын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд суурь материал болно гэдгийг үргэлж санах хэрэгтэй. Баримт бичигт сумын дараах судалгааг нарийн тусгасан болно. Үүнд:

- ✓ Мянганы хөгжлийн бодлого, аймгийн хөгжлийн бодлого
- ✓ Сумын хөгжлийн бодлогод уялдуулах
- ✓ Сум хөгжүүлэх чиг хандлага
- ✓ Сумын газар нутагтай холбоотой байгалийн төрх байдал нөөцийн судалгаа
- ✓ Нийгэм эдийн засгийн нөхцөл байдлын судалгаа
- ✓ Газар ашиглалтын судалгаа
- ✓ Газрын нөөц, ашиглалтын үнэлгээ
- ✓ Сумын газрын тохиромжтой байдлын үнэлгээ ашиглалтын төрөл бүрээр
- ✓ Сумын иргэдийн хэрэгцээт байдлын үнэлгээ
- ✓ Бэлчээрийн газрын эдийн засгийн чадавхийн үнэлгээ
- ✓ Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө
- ✓ Зүй ёсны эрхийн баталгаажуулалт

Төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавина гэдгийг анхаарах хэрэгтэй байна.

АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

1. Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, 2012 он
2. Газрын тухай хууль, 1995 он
3. Байгаль орчны тухай хуулиуд, 1997 он
4. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, 2002 он
5. Газрын хэвлийн тухай хууль. Байгаль орчны тухай Монгол Улсын хуулиуд, 1997 он
6. Хот байгуулалтын тухай хууль, 1998 он
7. Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм, дүрэм, 2004 он
8. “Аймаг, Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргазүйн заавар”, 2008 он
9. “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”, 2011 он
10. Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм
11. Монгол улсын стандарт MNS 4652-28
12. Монгол улсын стандарт MNS 4628-98 “Шатахуун түгээх станц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага”, 1998 он
13. “Харилцаа холбооны тухай хууль”, Засгийн газрын 2001 оны 263 дугаар тогтоол
14. "Авто замын тухай хууль"-ийн 12.2 зүйл
15. “Ойн тухай хууль” 2012 оны 5-р сарын 17
16. “Аялал жуулчлалын тухай хууль” 2000 оны 5-р сарын 5

Нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулахад хэрэглэгдэх заавар, стандартууд.

Аргачлал, стандарт	Тайлбар	
Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй	ГЗБГЗЗГ-ын газрын даргын 2017 оны 11-р сарын 24 өдрийн А/278 тушаал	
Тохиромжтой байдлын үнэлгээ хийх арга	ГЗГЗЗГ-ын даргын 2015 оны 09-р сарын 09-ны өдрийн А/200 тоот тушаал	
Бэлчээрийн ургац тодорхойлох арга зүй	БОНХ-ын сайдын 2011 оны А114 дүгээр тушаал	
Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэцийг тодорхойлох	Л.Г.Раменскийн квадрат торыг ашиглах арга./Избранные работы. Проблемы и методы изучения растительного покрова/ Изд. Наука. 1971 г.	
Бэлчээрийн багтаамж	ХХАА-н сайдын 2010 оны 148-р тушаал	
Бэлчээрийн хөрсний элэгдэл эвдрэл, зэрэглэл тогтоох	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль тогтоомжийн хялбаршуулсан лавлах, Улаанбаатар, 2012 “Бэлчээрийн хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага” MNS 5546:2005	
Бэлчээрийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, талхлагдал, зэрэглэл тогтоох		
Хөрсний бохирдолт	Хөрсний бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008	
Хар тугалга, кадмы, хром, зэс никель, кобальт, цайр	Атом шингэлтийн спектрометрийн арга MNS ISO 11047:2001	
Ургамлын арви үнэлэх	О.Друдегийн 1913 В ведение в геоботанику Изд. Ленинградского университета. 1964 г.	
Усжуулагдсан бэлчээрийн талбайг тодорхойлох	Усны аж ахуйн яам, УХСЗТИ “Усжуулагдсан бэлчээрийн талбайг тодорхойлох аргачлал”. Улаанбаатар 1971 он	
Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх аймаг, сумын жагсаалт	“Хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2002 оны 160-р тогтоолын 2-р хавсралт	
Малын төрлийг хонин толгойд шилжүүлэх	1997 оны Газрын төлбөрийн хуулийн 6-2, Үндэсний статистикийн хорооны хөдөө аж ахуйн салбарын тайлан, 2013	
Нийгэм-эдийн засгийн судалгаа	Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн боловсруулсан “Социологийн судалгааны арга зүй, аргачлал” УБ, 2008	
Шатсан ой, хортон мэрэгчид идэгдсэн ой	Ой зохион байгуулалтын материал	
ГЗБТөлөвлөгөөний зураг боловсруулах	MNS 6317: 2012, MNS 6316:2012 стандарт	
Усны чанарыг тодорхойлох стандартууд	Шинжилгээний үзүүлэлт	Хэрэглэж буй арга